

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2024 оны 01 дугаар сарын 04-ний өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 22
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	23 - 66
1. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал	24 - 48
2. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	48 - 66

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 51.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 22 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, Ж.Батсуурь, Ж.Бат-Эрдэнэ, С.Бямбацогт, Ж.Ганбаатар, Б.Жавхлан, Л.Мөнхбаатар, Г.Мөнхцэцэг, С.Одонтуяа, Д.Өнөрболор, Г.Тэмүүлэн, Н.Учрал, О.Цогтгэрэл, Б.Энх-Амгалан, Л.Энх-Амгалан, Б.Энхбаяр;

Чөлөөтэй: С.Амарсайхан, Ё.Баатарбилэг, Э.Батиугар, Б.Бат-Эрдэнэ, Б.Баярсайхан, Н.Ганибал, Х.Ганхуяг, Т.Доржханд, Б.Дэлгэрсайхан, Л.Оюун-Эрдэнэ, Б.Чойжилсүрэн, Т.Энхтүвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, М.Оюунчимэг, Ш.Раднаасэд;

Хоцорсон: С.Ганбаатар – 04 минут, Ц.Мөнхцэцэг – 02 минут, Б.Саранчимэг – 34 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ш.Адьяа нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ш.Адьяа нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Н.Энхболд, Г.Дамдинням нарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Нэг. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигч Д.Дэлгэрсайхан, Т.Сүхболд, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, чөлөөлөх асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ц.Даваасүрэн, Г.Дамдинням, Д.Ганбат, Б.Пүрэвдорж, Ц.Туваан нарын тавьсан асуулгад Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигч Д.Дэлгэрсайхан, Т.Сүхболд, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан саналыг нууц санал хураалтаар явуулав.

Г.Занданшатар: Дагвадоржийн Дэлгэрсайханыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 8
Бүгд: 40
80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Төмөрбаатарын Сүхболдыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 8
Бүгд: 40
80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Бямбажавын Ганбатыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 7
Бүгд: 40
82.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Жамсранжавын Болдыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 7
Бүгд: 40
82.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /11:34/

Уг асуудлыг 11 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга А.Өнөржаргал, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хуулийн хэлтсийн дарга Л.Нямдорж, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга Б.Батсайхан, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга П.Болормаа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч Г.Оюунболд, Боловсрол, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын шинжээч Б.Дуламсүрэн, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны мэргэжилтэн Э.Оюун-Эрдэнэ, Хүний эрхийн Үндэсний Комиссын судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Янжмаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Ж.Азжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын референт Г.Нямсүрэн, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлагын хугацаа дууссаныг мэдэгдэв.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор үргэлжлүүлэн санал хураалт явуулав.

Нэг.Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “байгуулж болно” гэснийг “байгуулна” гэж өөрчилж, мөн зүйлийн 6 дахь хэсгийн “Засаг даргын орлогч” гэсний дараа “, эсхүл тухайн аймаг, дүүргийн Засаг даргын ажлын албаны хуулийн асуудал хариуцсан нэгжийн дарга” гэж, 9 дэх хэсгийн “байгууллага,” гэсний дараа “сум дахь хууль зүйн хорооны нарийн бичгийн даргын үүргийг тухайн сумын хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “олон улсын байгууллагын төлөөлөл,” гэснийг, мөн зүйлийн 5

дахь хэсгийн “аймаг, дүүрэг,” гэснийг, 10 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн дараах байгууллагын удирдах албан тушаалтнаас бүрдэнэ:

2.1.нутгийн өөрөө удирдах байгууллагын ажлын алба;

2.2.аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, хэлтэс;

2.3.аймаг, дүүргийн боловсролын газар, хэлтэс;

2.4.аймгийн эрүүл мэндийн газар, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв;

2.5.аймаг, дүүргийн хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний газар, хэлтэс;

2.6.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын алба;

2.7.Засаг даргын ажлын албаны хуулийн асуудал хариуцсан нэгж;

2.8.аймаг, дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтэс;

2.9.аймаг, нийслэл, дүүрэг дэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс;

2.10.аймаг, дүүргийн прокурорын газар;

2.11.шүүхийн тамгын газар.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 14

Бүгд: 39

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2.12 дугаар зүйлийн 1.2 дахь заалтын “хүчирхийлэл үйлдсэн этгээдийг тогтоох зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлэхээс өмнө” гэснийг хасаж, мөн зүйлийн 1.3 дахь заалтын “зөвлөгөө,” гэсний дараа “эрх зүйн туслалцаа, мэдээлэл өгөх, гэж, мөн заалтын “саналаа хэлэх,” гэсний дараа “хүсэлт гаргах” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 1.7 дахь заалтын “газарт нь” гэснийг “газар, тусгай өрөөнд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 15

Бүгд: 39

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “ашиглах,” гэсний дараа “хүүхдийг үл хайхрах,” гэж нэмж, мөн зүйлийн 8 дахь хэсгийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 8 дахь хэсэг нэмэх:

“8.Хүүхдийн дэргэд согтууруулах ундаа хэрэглэх, эсхүл хэрэглэсэн үедээ хүүхдийн амьдарч, суралцаж байгаа орчин, орон байранд нэвтэрснийг хүүхдийг эрсдэлт нөхцөлд оруулсантай адилтгаж үзэж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ажлын хэсгийн гаргасан 14 дэх санал буюу төслийн 3.1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9 дэх хэсэг нэмэх:

“9.Эцэг, эх хүүхдээ эрсдэлт нөхцөлд орж болзошгүй соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолтод оролцуулах тохиолдолд гэнэтийн ослын даатгалд даатгуулна.” гэсэн саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3.2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 2.7 дахь заалт, 9, 10,11 дэх хэсгийг тус тус нэмэх:

“2.7.хичээлийн жилийн турш хүүхэд эрсдэлт нөхцөлд байгаа эсэхийг үнэлэх, зөвлөгөө өгөх, хүүхэд бүрийн нийгэм, сэтгэл зүйн асуудлыг илрүүлэх, тандан судлах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх;

9.Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлагыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

10.Боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвд суралцаж байгаа хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдлын тандалт судалгааг гурван жил тутам Боловсролын ерөнхий хуулийн 17.2-т заасан байгууллага хийнэ.

11.Боловсролын ерөнхий хуулийн 40.2.8-д заасан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн төлөөллийн байгууллага хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын төлөвлөгөөтэй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 12
Бүгд: 38
68.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.11 дэх заалт, 4.5.2 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2.11 дэх заалтыг 2.12, 2.13 дахь заалт болгох:

“1.Боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төв, сүм хийд, шашны сургууль нь хүүхэд хамгааллын бодлого, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна.

2.12.хүүхэд тодорхойгүй шалтгаанаар хичээлдээ ирээгүй тохиолдолд гэр бүл, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нэн даруй мэдэгдэх;

2.13.хүүхэд эрсдэлт нөхцөлд өртсөн талаар мэдсэн, таамагласан, илрүүлсэн бол харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд мэдэгдэх.

4.5.2.сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг үзүүлэх, хүүхдийн төлөвшилд нөлөөлөх сургалт, үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамт хамруулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн:	22
Татгалзсан:	16
Бүгд:	38

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3.2 дугаар зүйлийн 4.5.1 дэх заалтын “сануулах” гэсний дараа “зөвлөгөө өгөх, хохирогч суралцагчаас уучлалт гуйлгуулах” гэж, мөн зүйлийн 5.5 дахь заалтын “эрсдэлд нөхцөлд” гэсний өмнө “боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн сургалтын хөтөлбөрт” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “Боловсролын сургалтын байгууллагын удирдлага, хүүхдийн эрх, хамгааллын үйлчилгээ үзүүлэх нэгж” гэснийг “Боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төв” гэж, мөн хэсгийн “мэдээллийн мөрөөр нэн даруй хяналт шалгалт явуулж” гэснийг “мэдээллийг хүлээн авч,” гэж, мөн зүйлийн 4.5 дахь заалтын “суралцагчийг сургалт, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд хамруулах,” гэснийг “хүүхдэд” гэж, мөн зүйлийн 6 дахь хэсгийн “Шашны байгууллага /сургууль/-ын дэргэдэх” гэснийг “Боловсролын сургалтын байгууллага, сүм хийдийн” гэж, 8 дахь хэсгийн “Шашны байгууллага /сургууль/-д суралцах хүүхэд, түүний гэр бүлд” гэснийг “Боловсролын сургалтын байгууллага, сүм хийдийн орчны аюулгүй байдалд” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 4.4 дэх заалтын “, удаа дараа хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртсөн суралцагч, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрснөөр өөр бүлэг, сургууль руу шилжүүлэх” гэснийг, мөн зүйлийн 4.5.3, 4.5.4 дэх дэд заалт, 4.6, 4.7, 5.1, 5.3, 5.6 дахь заалт, 9 дэх хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	27
Татгалзсан:	11
Бүгд:	38

71.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “байгууллага” гэсний дараа “эрсдэлд нөхцөлд байгаа” гэж нэмж, мөн зүйлийн 5.1, 5.3 дахь заалт, 6 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 11
Бүгд: 38

71.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа” гэснийг “хүүхдэд хортой агуулга” гэж өөрчилж, мөн зүйлийн 3-11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3-13 дахь хэсэг болгох:

“3.Хүн, хуулийн этгээд хүүхдийг цахимаар урхидах, дээрэлхэх, дарамтлахыг хориглоно.

4.Хүн, хуулийн этгээд хүүхдийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон, эсхүл хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийн зураг, дуу, дуу-дүрсний бичлэг агуулсан контент, мэдээ, мэдээлэл, бүтээлийг олон нийтэд түгээхийг хориглоно.

5.Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчны үйлчилгээ эрхлэгч өөрийн үйлчилгээнд хориотой агуулгыг түгээхгүй байх, хүүхдэд хортой агуулгыг хянах, хязгаарлах, хаах арга хэмжээ авах үүрэгтэй.

6.Интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэрийн дагуу цахим орчинд түгээсэн хүүхдэд хортой болон хориотой агуулгыг өөрийн сүлжээнд хязгаарлалт хийх технологийн арга хэмжээг авна.

7.Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч контент, бүтээлийг олон нийтэд түгээхийн өмнө насны ангиллын тэмдэглэгээг байршуулна.

8.Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч хүүхдийг хориотой, хүүхдэд хортой агуулгаас хамгаалах зорилгоор насанд хүрэгчдэд зориулсан тохиргоог идэвхжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

9.Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч Харилцаа холбооны зохицуулах хорооны мэдэгдэлд заасан хориотой, хүүхдэд хортой агуулгыг өөрийн үйлчилгээнд хязгаарлах, хаах үүрэгтэй.

10.Хүн, хуулийн этгээд хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчинд хориотой агуулга түгээснээс хүүхдийн эрх зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй гэж үзвэл гомдлоо хүүхдийн эрхийн улсын байцаагч, цагдаагийн байгууллагад гаргаж, шийдвэрлүүлнэ.

11.Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль, зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

12.Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл

нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллана.

13.Энэ зүйлийн 12-т заасан орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38
63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3.4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараах тайлбар хэсэг нэмэх:

“Тайлбар:Энэ зүйлд заасан “цахим орчны үйлчилгээ эрхлэгч” гэж цахим хуудас, цахим хэрэглүүр /аппликэйшн/, платформ, цахим орчин ашиглаж контент, бүтээлийг олон нийтэд хүргэх үйлчилгээ үзүүлэгч этгээдийг ойлгоно.

Энэ зүйлд заасан “цахимаар урхихдах” гэж хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд уруу татах зорилгоор цахим сүлжээ ашиглан хүүхэдтэй харилцаа тогтоохыг хэлнэ.

Энэ зүйлд заасан “цахимаар дээрэлхэх” гэж цахим орчинд хүүхдийг дээрэлхэж, гадуурхсан, айлган сүрдүүлсэн, доромжилсон зүй бус агуулга бүхий мэдээ, мэдээллийг өөрт нь болон бусдад түгээхийг хэлнэ.

Энэ зүйлд заасан “цахимаар дарамтлах” гэж хүүхдийг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг шаардаж өөрт нь, түүний ойр дотны хүний эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар цахим сүлжээнд сүрдүүлэхийг хэлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38
63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3.5 дугаар зүйлийн 2, 6 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмэх:

“5.Сум, дүүргийн Засаг дарга, хүүхдийн эрхийн улсын байцаагч худалдаа, үйлчилгээний газар, боловсролын сургалтын байгууллагаас гадуурх сургалтын ажил эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хүүхдийн эрх зөрчигдөж байгаа эсэхэд хяналт тавьж, хүүхдийг эрсдэлт нөхцөлд оруулсан бол уг үйл ажиллагааг хязгаарлах, зогсоох арга хэмжээ авна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18

Бүгд: 38
52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3.6 дугаар зүйлийн 9, 10 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “оролцуулахдаа” гэсний дараа “хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах,” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “дасгалжуулагч,” гэсний дараа “зохион байгуулагч” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 5.2 дахь заалтын “хамруулж, өсөлт, хөгжлийн талаар дүгнэлт гаргуулах” гэснийг “хамруулах” гэж өөрчлөн мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5, 6 дахь хэсэг, тайлбар хэсгийг тус тус нэмэх:

“5.Хүүхдийг оршин суугаа газраас өөр газарт 24 цагаас дээш хугацаагаар соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, спортын тэмцээн, бусад арга хэмжээнд оролцуулахад 15 хүртэлх хүүхэд тутамд нэг багш, дасгалжуулагч ажиллаж, хүүхдийн аюулгүй байдлыг хангана.

6.Үндэсний их баяр наадмын тухай хуульд зааснаас бусад хурдан морины уралдааныг зохион байгуулах тохиолдолд зохион байгуулагч нь хурдан морины уралдааны бэлтгэлийн үе эхлэхээс өмнө харьяа сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэж, бүртгүүлнэ.

Тайлбар:Энэ зүйлд заасан “уяач” гэдгийг хурдан морины уралдаанд уралдаж байгаа морины өмчлөгчийг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 25
Бүгд: 38
34.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

23.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, Төслийн 3.7 дугаар зүйлийн гарчгийн “онцгой нөхцөл байдлын нөхцөлд байгаа” гэснийг “гамшгийн онцгой нөхцөл байдлын” гэж, мөн зүйлийн “онцгой” гэснийг “гамшгийн онцгой нөхцөл” гэж тохиолдол бүрд өөрчилж, мөн зүйлийн 6, 7 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмэх:

“5.Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед хүүхдийг насанд хүрсэн хүнд харгалзуулалгүйгээр орхих, хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахаас бусад тохиолдолд хүүхдийг байгаа газраас нь авч явах, тээвэрлэхийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 22
Бүгд: 38

42.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3.8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “нас,” гэсний дараа “хүйс,” гэж нэмж, мөн хэсгийн “таатай орчинд” гэснийг “тусгай өрөөнд” гэж өөрчилж, мөн зүйлийн 7 дахь хэсгийг хасах” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ” гэснийг “ХОЁРДУГААР БҮЛЭГ” гэж өөрчилж, 4.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг хасах” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38

60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “30.1.1, 30.1.3” гэснийг “30.1” гэж өөрчилж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “нөхцөл байдалд ороогүй” гэсний дараа “ нь аюулын зэргийн болон эрсдэлийн үнэлгээгээр тогтоогдсон” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38

52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “хүүхдийг гэр бүлээс нь түр тусгаарлах” гэснийг “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30.1-д” гэж өөрчлөх” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “гэрээ байгуулж болохгүй хүн болох нь хожим илэрсэн,” гэснийг “гэрээг цуцлах үндэслэл” гэж, мөн хэсгийн “цуцалж, хүүхдийг буцаан авна” гэснийг “цуцална” гэж, мөн зүйлийн 6

дахь хэсгийн “цуцалж, хүүхдийг буцаан өгч” гэснийг “цуцалж” гэж тус тус өөрчлөх” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ажлын хэсгийн гаргасан 30 дахь санал буюу төслийн 4.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “орон нутгийн байгууллага,” гэсний дараа “хамтарсан баг” гэж нэмж, мөн хэсгийн “кейс менежмент” гэснийг “тохиолдлын зохицуулалт /кейс менежмент/” гэж, “кейс” гэснийг “тохиолдол /кейс/” гэж тохиолдол бүрд өөрчлөх” гэсэн саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6.1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 6 дахь хэсэг нэмэх:

“6.Засгийн газрын гишүүн бүр эрхлэх асуудлын хүрээнд салбарын хүүхэд хамгааллын үйлчилгээ, энэ хуулийн 4.1 дүгээр зүйлийн 3-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгуулах арга хэмжээ авна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтэд дараах журмаар хяналт тавина:

1.1.аймаг, нийслэлийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага өөрийн хариуцсан салбарын хүрээнд хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр тухайн жилд гүйцэтгэсэн ажлын тайланг дараа оны 2 дугаар сард багтаан хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

1.2.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ зүйлийн 1.1-д заасны дагуу ирүүлсэн тайланд дүн шинжилгээ хийж, жил бүрийн 3 дугаар сард багтаан Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөр хэлэлцэх;

1.3.Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл шаардлагатай тохиолдолд Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох төрийн байгууллагад чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7.4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Энэ хуулийг 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн дэс дараалал, бүлэг, зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2.6 дугаар зүйлийн 1.6 дахь заалтын “судалгаа хөтөлж,” гэсний дараа “хүүхэд хамгааллын нэгдсэн” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмэх:

“5.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын дарга Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн байгууллагад 4-өөс доошгүй жил, үүнээс хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнаар хоёроос доошгүй жил ажилласан байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 20
Бүгд: 38
47.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 20
Бүгд: 38
47.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

НАЙРУУЛГЫН САНАЛ

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3.4 дүгээр зүйлийн гарчгийн “мэдээлэл,” гэсний дараа “өргөн нэвтрүүлэг,” гэж нэмэх.

2.Төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.11 дэх заалтын “тодорхой” гэснийг “гэрээнд заасан” гэж, 2.9 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтын “жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан” гэснийг “жилд хоёроос доошгүй удаа” гэж, 3.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Боловсролын сургалтын байгууллагын хүүхдийн эрх, хамгааллын үйлчилгээ үзүүлэх нэгж нь хүүхэд сургалтын” гэснийг “Энэ зүйлийн 1-д заасан байгууллагын” гэж, мөн зүйлийн 2.3 дахь заалтын “хайрцаг байрлуулах” гэснийг “нээлттэй суваг ажиллуулах” гэж, мөн зүйлийн 5.5 дахь заалтын “агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын багш бэлтгэх, давтан сургах сургалтын хөтөлбөрт тусгаж,” гэснийг “агуулга туссан эсэхэд” гэж, 3.6 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “дүүргийн” гэснийг “баг, дүүрэг, хорооны” гэж өөрчилж, 7.3 дугаар зүйлийн гарчгийн “Шилжилтийн үеийн” гэснийг “Хууль дагаж мөрдөх журмын” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “хууль тогтоомж,” гэснийг, мөн зүйлийн тайлбар хэсгийн “тухайн хуулийн этгээдийн ажилтны болон үйлчлүүлж байгаа” гэснийг, 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “хувийн эрх зүйн” гэснийг, 2.12 дугаар зүйлийн 1.4 дэх заалтын “тогтмол хугацаанд” гэснийг, 4.3 дугаар зүйлийн 2.4 дэх заалтын “хөгжлийн, амьдрах ухааны” гэснийг, мөн заалтын “тохиромжтой үйл ажиллагаанд” гэснийг тус тус хасах” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

НЭГ.ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, П.Анужин, Б.Баярсайхан, Б.Бейсен, Б.Жаргалмаа /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан,

Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын 20.8 дахь хэсгийн “хяналт шалгалт хийхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг баримтлах ба хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүрмийг Засгийн газар батална” гэснийг “хүүхэд аюултай нөхцөл байдалд орсон, орсон байж болзошгүй тохиолдолд хяналт шалгалт явуулах аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламж, ажлын байр, орон байранд урьдчилан мэдэгдэхгүйгээр чөлөөтэй нэвтрэх эрхтэй” гэж өөрчилж, мөн зүйлийн 7 дахь заалтад доор дурдсан агуулгатай 20.9 дэх хэсэг нэмэх:

“20.9.Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн ажиллах дүрмийг Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	22
Татгалзсан:	16
Бүгд:	38

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 8 дахь заалт нэмэх:

8/20¹ дугаар зүйл:

“20¹ дугаар зүйл.Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч

20¹.1.Сум, дүүргийн Засаг дарга баг, хороо бүрд хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч ажиллуулж болно.

20¹.2.Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч тухайн сум, хорооны байнгын оршин суугч байна.

20¹.3.Сум, дүүргийн Засаг даргын захирамжийг үндэслэн Тамгын газрын дарга хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагчтай гэрээ байгуулах бөгөөд гэрээнд талуудын эрх, үүрэг, хариуцлага, ажил тайлагнах журам, урамшуулал, гэрээ цуцлах үндэслэлийг тусгана.

20¹.4.Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагчтай байгуулсан гэрээг ажлын үр дүнг харгалзан жил бүр сунгана.

20¹.5.Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

20¹.5.1.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, мэдээлэх;

20¹.5.2.хүүхэд эрхээ хэрэгжүүлэхэд нь зөвлөгөө өгөх, тусалцаа үзүүлэх;

20¹.5.3.хүүхдийн сайн сайхан байдлыг хангахад чиглэсэн санал, санаачилга гаргаж хэрэгжүүлэх;

20¹.5.4.хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

20¹.5.5.хүүхдийн эрхийн зөрчлийн талаар эрх бүхий этгээдэд мэдэгдэж, шийдвэрлүүлэх.

20¹.6.Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хамтарсан баг, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтантай хамтран ажиллана.

20¹.7.Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч нь ажлын улирал тутмын төлөвлөгөөг сум, дүүргийн Засаг даргаар батлуулна.

20¹.8.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагчийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулна.

20¹.9.Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч сум, дүүргийн Засаг даргаас олгосон албаны үнэмлэхтэй байна. Албаны үнэмлэхийн загварыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

20¹.10.Сум, дүүргийн Засаг дарга хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагчид олгох урамшууллын зардлыг орон нутгийн төсвийн төсөлд тусгаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, үр дүнг тайлагнана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 19

Бүгд: 37

58.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 15

Бүгд: 38

60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 14

Бүгд: 38

63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “15 дугаар зүйлийн 15.1.9 дэх заалтын дугаарлалтыг “15.1.10” гэж,” гэснийг хасаж, мөн зүйлийн ““20.5, 20.6, 20.7”

дахь хэсгийн дугаарлалтыг “20.9, 20.10, 20.11” гэснийг “20.5 дахь хэсгийн дугаарыг “20.10” гэж, 20.7 дахь хэсгийн дугаарыг “20.12” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмэх:

“5 дугаар зүйл.Хүүхдийн эрхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38
63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

ХОЁР.ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 2, 3 дахь заалт нэмэх:

“2/30 дугаар зүйлийн 30.11 дэх хэсэг:

“30.11.Хүүхдийн түр хамгаалан байрлуулах үйлчилгээг төрөлжүүлэн зохион байгуулж болно.”

3/35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэр:

“Төрийн байгууллагын харьяанд байгуулсан түр хамгаалах байрны урсгал зардал, түр хамгаалан байрлуулж энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлэх зардлыг тухайн байгууллага хариуцна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 1, 2 дахь заалт нэмэх:

1/18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт:

“18.1.2.Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардал, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх;”

2/19 дүгээр зүйлийн 19.1.5 дахь заалт:

“19.1.5.тухайн шатны жилийн төсвийн төсөлд нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг тусгаж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 13
Бүгд: 38
65.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “сургуулийн,” гэсний дараа “нийгмийн” гэж, мөн хэсгийн “тухайн сум,” гэсний дараа “баг,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 13
Бүгд: 38
65.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “хуулийн” гэсний дараа “5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтын “гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан баг” цаашид “хамтарсан баг” гэх/” гэснийг “хамтарсан баг” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 13
Бүгд: 38
65.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

ГУРАВ.ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 5.2.5 дахь заалтын “байгуулах” гэснийг “байгуулж, ажиллах журмыг батлах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38
63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

ДӨРӨВ.НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 19¹.2 дахь хэсгийн “хувь хүн,” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2/13 дугаар зүйлийн 13.13, 13.14 дэх хэсэг:

13.13.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах тохиолдолд хүүхдийн тэтгэмжийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид олгохыг түдгэлзүүлэх шийдвэр гаргана:

13.13.1.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь сураггүй алга болсон;

13.13.2.эцэг, эх нь хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй, эсхүл эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн эрхийг зөрчсөн талаар аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүгнэлт гарсан, хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон.

13.14.Энэ хуулийн 13.1.6-д заасан хүүхдийн мөнгөн тэтгэмжийг зээл, өр төлбөрт суутгахыг хориглоно” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт болгон шилжүүлж, 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3 дугаар зүйл болгох:

“3 дугаар зүйл.Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дэх заалтын, 19 дүгээр зүйлийн 19.1.3, 19.2.3 дахь заалтын “хүнд нөхцөлд” гэснийг “эрсдэлт нөхцөлд” гэж, 13 дугаар зүйлийн 13.13 дахь хэсгийн дугаарыг “13.15” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 4 дүгээр зүйл болгох:

“4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38
63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

ТАВ.ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

ЗУРГАА.ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “сурагчдад” гэсний өмнө “оюутан,” гэж, мөн зүйлийн “хүүхдэд” гэсний өмнө “дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагч, эрсдэлт нөхцөлд байгаа” гэж тус тус нэмэх” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

ДОЛОО.ОНЦ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

НАЙМ.ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчгийн “, ӨӨРЧЛӨЛТ” гэснийг “ОРУУЛАХ” гэж өөрчилж, 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналын томъёололтой холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат үг хэлэв.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 13
Бүгд: 37
64.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

ЕС.ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 16
Бүгд: 37
56.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Үдээс өмнөх хуралдаан 12 цаг 33 минутад завсарлав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 14 цаг 31 минутад хуралдаан өндөрлөснийг мэдэгдэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг, Б.Баярсайхан нарын урилгаар Завхан аймгийн Цэцэн-Уул сумын иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 2 цаг 15 минут үргэлжилж, 72 гишүүнээс 41 гишүүн хүрэлцэн ирж, 56.9 хувийн ирцтэйгээр 14 цаг 32 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 22 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Гишүүдийн ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал нэгдүгээрт хэлэлцэнэ.

Хоёрдугаарт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна.

Гуравдугаарт, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т заасны дагуу гишүүд энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон

асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол өмнөх өдрийн 17.00 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж, Ширнэнбаньдийн Адьшаа нараас бичиг ирүүлсэн байна.

Ингээд Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Монголын ард түмэнд болон Их Хурлын гишүүддээ шинэ жилийн баярын мэндийг, шинэ оны мэндийг өргөн дэвшүүлье.

Шинэ оны эхэн дээр өнгөрсөн жилийнхээ парламентын болон хувийнхаа ололт амжилтыг ярьсан нь зүйтэй гэж үзлээ.

Тэгэхээр өнгөрсөн жилийн хугацаанд 2023 онд нийтдээ Ховд аймагт 83 уулзалтыг зохион байгууллаа.

Бусад аймгийн 21 томоохон сум дээр уулзалт хийсэн.

Мөн бусад аймгийн төвийн 4 төв дээр уулзалт хийсэн байна.

Ингээд нийтдээ 108 уулзалтыг өнгөрсөн бүтэн жилийн хугацаанд хийсэн байна. 3 өдөр тутмын нэгийг нь иргэдтэй уулзалт хийх ажлыг зохион байгуулж ажилласан байна.

Улсын Их Хурлын индэр дээрээс 96 иргэний үгийг төрийн байгууллага болон Улсын Их Хурал, яам, Тамгын газар, агентлагт хандаж үг хэллээ.

Тэрний 30 орчим иргэний асуудлыг хойноос нь хөөцөлдөж шийдвэрлэсэн байгаа. Энэ бол зөвхөн хувь хүний асуудал биш шүү. Нийтлэг эрх ашгийн асуудлыг л би ярьдаг гэдгээ хэлье.

Энэ уулзалтуудаас үүдээд нийтдээ **21** хуулийг би өнгөрсөн **3** жилийн хугацаанд өргөн барьсан. Түүний **5-ыг** нь батлуулсан амжилтыг гаргалаа.

Тэгэхээр энэ олон уулзалт, энэ олон хууль Их Хуралд өргөн барьсан, үг хэлсний үр дүн юу юм бэ. Үр дүн хамгийн гол нь чухал байх ёстой.

Тэгэхээр батлагдсан нийгмийн даатгалын багц хуультай хамт миний өргөн барьсан **3** хууль Хамтын тэтгэврийн тухай хуулийн хүрээнд **9.4** тэрбум төгрөг манай ахмадууд дээр очиж байгаа.

Тэтгэврийг өвлөх гэж ярьж байгаа. Гол нь Хамтын тэтгэврийн тухай хуулийн хүрээнд.

Мөн түүнчлэн **7** жил биш **5** жилийн хуулийн хүрээнд **20.6** тэрбум төгрөг очиж байгаа.

Энэ бол Засгийн газар хэрэгжүүлэх дээрээ хэтэрхий бага тавиад энэ хуулийг гажуудуулсан тохиолдол байгаа.

Энэ хуулийн хүрээнд миний өргөн барьсан тэр концепцоор бол **140.0** тэрбум төгрөг өгчих ёстой. Гэвч харамсалтай нь Засгийн газар тогтоол гаргаж энэ хуулийг гажуудуулсан. Энэ талаар маргааш өглөө ярина.

Мөн түүнчлэн тэтгэврийг индексжихүүлэх буюу энэ жил Монголбанк, Засгийн газар эдийн засгийг буруу удирдсаны үр дүнд хэдэн хувийн инфляц бий болно тэр хувиар нь ирэх оны 01 сарын 01-нээс тэтгэвэр нэмдэг.

Энэ тэтгэврийг индексжүүлэх тухай хуулийн хүрээнд **449.3** тэрбум байх. Ийм төгрөгийн тэтгэвэр ахмадуудад очиж байгаа.

Ингээд нийтдээ миний өргөн барьсан **3** хуулийн хүрээнд **480.0** тэрбум төгрөгийн тэтгэвэр нэмэгдэх ийм боломж бүрдсэн байгаа.

Мэдээж энэ бол хэдийгээр би өргөн барьсан боловч өнөөдөр энд сууж байгаа Монгол Ардын намын гишүүд олонхтой парламент үүнийг баталсныг цохон тэмдэглэж Та бүхэнд, ялангуяа Монгол Ардын намын гишүүд Та бүхэнд бас талархсанаа илэрхийлэх ёстой гэж үзэж байна. Мөн түүнчлэн манай сөрөг хүчний гишүүд энэ тал дээр маш идэвхтэй ажилласныг хэлье.

Ингээд Та бүхэндээ энэ жил улам их ард иргэдийнхээ төлөө, сонгууль ч дөхөж байна. Та нар чинь их гоё гоё юм гаргах байх. Тэгээд сонгуулийн бус жил сайн ажиллаж байгаарай гэж Та бүхэнд хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар:
Ширнэнбаньдийн Адьшаа гишүүн.

Ш.Адьяа: 2024 он гарлаа. Их Хурлын гишүүддээ, нийт монгол

түмэндээ 2024 оны шинэ жилийн мэнд дэвшүүлэе.

Монгол Улсын парламент Засгийн газартаа хяналт тавих Үндсэн хуулийн зарчим өнөөдөр хэрэгжихгүй байна. Монгол Улсын парламентын тухайд.

Монгол Улсын Засгийн газраас 2023 оныг Авлигалтай тэмцэх жил болгоноо гэсэн. Хууль эрх зүйн орчинг шинэ шатад гаргана гэсэн. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн тухай, Шүүх байгуулах тухай хуулийг нэн яаралтай горимоор хэлэлцүүлнэ гэж Засгийн газраас өргөн бариад хоёр сар болж байна. Хоёр сар болж байна.

Яагаад оруулж ирэхгүй байгаа юм. Үндсэн хуулийн үзэл баримтлал зөрчсөн байхгүй юу даа. Тэгээд энэ Засгийн газартайгаа бид юу ч ярьж чадахгүй байна.

Авлигалтай тэмцэх, хууль эрх зүйн орчныг шинэ түвшинд гаргана, авлигын шүүх байгуулна гэсэн. Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулахад хүн гэдэг ангилалыг оруулж ирж жирийн сэтгүүлчид үнэн үг хэлсэн ард иргэдээ мөрдөх, цагдах ийм ажлыг шинэ сайд оруулж ирсэн юм.

Олон нийтийн эсэргүүцэлтэй тулгараад энэ нь замхарсан. Гэтэл өнөөдөр Монгол Улсад хууль, шүүхийн өмнө бүх хүн тэгш байна гэдэг зарчим чинь энэ Засгийн газрын Хууль зүйн сайдад үйлчлэхгүй байна.

Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг яагаад хасчихав. /минут дуусав/

Г.Занданшатар: Та 17 цаг 26 минут. Цаг чинь дууссан байна.

Нэг.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал

Ингээд хэлэлцэх асуудалдаа орно. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жамьянхорлоогийн Сүхбаатар танилцуулна.

Ж.Сүхбаатар: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, чөлөөлөх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос нэр дэвшүүлсэн Дагвадоржийн Дэлгэрсайхан, Төмөрбаатарын

Сүхболд нар нь Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022 оны 15 дугаар тогтоолоор баталсан нэр дэвших тухай хүсэлтийн загварын дагуу материалаа бүрдүүлж Байнгын хороонд ирүүлсэн болно.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүд нэр дэвшигч нартай хийсэн нэр дэвшигчийн сонголыг Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-ын хорооны гишүүний 5-ыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, 2-ыг Монгол Улсын Ерөнхийлөгч, 2-ыг Улсын Дээд шүүх төрийн жинхэнэ албан хаагчдаас санал болгосноор Улсын Их Хуралд нэр дэвшигчийн сонголт хийж 6 жилийн хугацаагаар томилно.

4.5.хорооны гишүүний бүрэн эрх нь түүнийг томилсон Улсын Их Хурлын шийдвэр гарснаар эхэлж, дараагийн гишүүн томилогдсоноор дуусгавар болно гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасны дагуу нэр дэвшигчийн сонголт явуулах үе шатыг баримтлан дараах ажиллагааг явууллаа.

2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт заасны дагуу нэр дэвшигчийн сонголын товыг тогтоох, сонголт даргалагчийг томилох тухай Байнгын хорооны тогтоолыг баталж, 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр нэр

дэвшигчийн сонголыг зохион байгуулахаар тов тогтоож, сонголт даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарыг томилсон.

2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 14.00 цагт Нийтийн сонголын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэгт Улсын Их Хурлаас зохион байгуулах, нэр дэвшигчийн сонголт тухайн асуудал эрхэлсэн Байнгын хорооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь оролцох гэж заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь буюу Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, Г.Занданшатар, Ц.Мөнхцэцэг, Д.Сарангэрэл, Ж.Сүхбаатар, Д.Тогтохсүрэн, Н.Энхболд нар Байнгын хорооны сонголт хүрэлцэн ирж ирц бүрдэж нэр байгуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 127 дугаар зүйлд сонголт оролцсон гишүүд сонголт явуулснаас хойш ажлын хоёр өдрийн дотор хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонголын тайлан гаргана.

Тайлан, сонголын дүнд үндэслэн тухайн нэр дэвшигч албан тушаалд шаардлага хангасан эсэх дүгнэлт, түүний үндэслэлийг тусгана.

Тухайн тайланг ажлын 5 өдрийн дотор нэр дэвшигч, түүний санал болгосон этгээдэд хүргүүлж Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулна гэж заасны дагуу 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд

оролцсон гишүүд санал нэгтгэйгээр сонсголын тайланг дэмжсэнийг Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулсан.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос нэр дэвшүүлсэн Дагвадоржийн Дэлгэрсайхан, Төмөрбаатарын Сүхболд нарыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилуулах саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Нэр дэвшигчдийн танилцуулга, Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Мөн чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан Б.Ганбат, Ж.Болд нарыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, чөлөөлөх асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Дагвадоржийн Дэлгэрсайхан, Төмөрбаатарын Сүхболд нар хүрэлцэн ирсэн байна.

Тэгээд энэ сонгууль зохион байгуулах үүрэгтэй төрийн байгууллагуудын дарга нар албан тушаалаараа шууд ордог. Энэ хуульд тэгж нэрээр биш уг нь албан тушаалаар нь оруул.

Цагдаагийн ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга нар төлөөлж орж байгаа шүү дээ.

Тэгээд энэ хоёрын дарга нар нь чөлөөлөгдөхөөр сонсгол энэ тэр гээд нэлээн ажилтай болчихсон. Тэгээд үүнийг нь хуульд нэг мөр. Нямаагийн Энхболд дарга аа, Төрийн байгуулалтын байнгын хороо ер нь.

Тэгээд зарим хүн нь гарч ордоггүй, нэр усаа өгдөггүй. Өргөдлөө өгөхгүй болохоор зарим нь Ерөнхийлөгчийн Тамгын газраас томилогдсон хүмүүс, Дээд шүүхээс томилогдсон хүмүүс ажил, албан тушаалаасаа өгчихсөн байтал ажил үүргийн дагуу оролцох хүмүүс нь тэгээд өргөдлөө өгдөггүй. Ингээд сонгуулийн зохион байгуулах асуудал дээр хүндрэл учруулах байдаг.

Ардчилсан намын төлөөлөл гэдэг юм уу, Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга хүмүүс нь ярьж тохироод орчихсон байда. Тэгтэл бусад хүмүүс нь ажлаа өгдөггүй нэг ийм зөрчилтэй асуудал үүсээд байгаа.

Хуульд нь өөрчлөлт оруулаад шийдчихмээр юм билээ.

Ингээд албан тушаалаар орж байгаа учраас энэ тэгээд шулуухан шуурхай шийдсэн нь уг нь зөв байх.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлт, эрх бүхий албан тушаалтны саналаас асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Г.Дамдинням гишүүнээр тасаллаа. Д.Ганбат гишүүнийг оруулья. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн хоёрыг орууллаа.

Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Хэлэлцэж байгаа асуудлыг дэмжиж байгаа юм. Сая Их Хурлын дарга ч дурдлаа.

Бид цаашдаа Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулж хоёр ангилж өгмөөр байгаа юм. Энэ сонгуулийн хорооны гишүүдийг.

Нэгдүгээрт нь, албан тушаалаар орж байгаа хүмүүсийг албан тушаалаар нь явдаг болгочихмоор байгаа юм. Тэр томилгооны сонсгол хийхгүй. Тухайлбал, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын дарга хоёр яг албан тушаалаар орж байгаа хоёр хүн байхгүй юу.

Тийм учраас цаашид ингэнэ. Бусад хүмүүсийн тухайд хуулиараа явж болно. Гэхдээ нэг асуудал байгаа юм.

Бид чинь 2008 оноос өмнө Сонгуулийн ерөнхий хороог улс төрийн намд бүрдүүлдэг байсан юм. 2008 оноос хойш төрийн албан хаагчдаас бүрдүүлдэг болсон байхгүй юу.

Гэтэл төрийн албан хаагчид чөлөөлөгдчихөөд тэгээд Сонгуулийн хорооны гишүүнээр байгаад байгаа юм.

Тэгэхээр цаашдаа хуульд өөрчлөлт оруулж төрийн алба хаагчид чөлөөлөгдвөл Сонгуулийн ерөнхий хорооноос чөлөөлөгддөг ийм эрх зүйн орчныг бас бүрдүүлж өгөх ёстой гэж ингэж бодож байгаа юм.

Би Цагдаагийн ерөнхий газрын даргаас хоёр зүйлийг асууя гэж бодож байгаа юм.

2024 оны сонгуульд сөрөг нөлөөлөх хоёр хүчин зүйл гараад ирчхээд байгаа юм.

Нэг дэх нь, социал медиа орчим байгаа юм.

Албан бус мэдээгээр Монгол Улсад **2.6 сая** фэйсбүүк хэрэглэгч байна гээд байгаа юм. Фэйсбүүк хаяг хэрэглэгч. Үүний **1.5 сая** нь хуурамч хаяг байна гээд байгаа юм.

Тэгэхээр одоо сонгууль ингээд эхэлж байна. Зүгээр жирийн үед ч одоо ингээд л байнга л гөвж байна. Хүмүүсийг. Ялангуяа Их Хурлын гишүүд, улс төрчдийг гөвж л байна.

Тэгэхээр би юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр үүнийг сонгуулийн үед доромжилсон, гүтгэсэн, харлуулсан

энэ хуурамч хаягуудыг илрүүлэх техникийн болон эрх зүйн боломж байна уу?

Бид энэ чиглэлээр хууль гаргасан. Харамсалтай нь тэр хууль Ерөнхийлөгчийн хориг тавиад тэгээд Их Хурал хүлээгээд авчихсан. Хэрэгжүүлж чадаагүй. Тэгээд энэ бол сонгуульд аягүй сөргөөр нөлөөлнө. Одоо зарим нь эхэлчихсэн байгаа юм. Хүний цус хүртэл шинжлээд эхэлчихсэн байна лээ. Тийм.

Тийм учраас ийм балиар юмаар ингээд сонгуулийн сурталчилгаа явдаг байхгүй юу. Удам судраар нь, ах дүүгээр нь доромжлоод.

Хоёр дахь асуудал бол хиймэл оюун ухаантай холбоотой асуудал байгаа юм.

Одоо энэ хиймэл оюун ухаанаар тэгээд социал медиагаар дамжуулаад л хүний үйлдээгүй үйлдлийг үйлдсэн болгож харуулдаг, хэлж яриагүй юмыг яг дуурайж хэлж ярьсан болгодог.

Үүнийг илрүүлэх, хариуцлага тооцох боломж байна уу? Техникийн болон эрх зүйн хүрээндээ. Ийм хоёр зүйлийг асууя. Баярлалаа.

Г.Занданшатар: 85.
Цагдаагийн ерөнхий газрын дарга Төмөрбаатарын Сүхболд.

Т.Сүхболд: Эрхэм гишүүний асуултад хариулья.

Таны хэлдэг үнэн. Монгол Улс Азидаа социал медиа, фэйсбүүк

эрхлэгч дээрээ тэргүүн байранд явж байгаа.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд тролл хаяг, хуурамч хаягийг илрүүлэх чиглэлээр бид ажиллаж байгаа.

Би томилогдсоноосоо хойш Кибер гэмт хэрэгтэй тэмцэх 40 хүний бүрэлдэхүүнтэй хэлтсийг 80 хүний бүрэлдэхүүнтэй болгож газар болгосон.

Техник хэрэгсэл, хүн хүч, алба хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр нэлээдгүй ажил хийсэн. Яг энэ чиглэлээр төгссөн залуучуудыг авч ажиллуулж байгаа.

Бидэнд техникийн боломж бас дутуу байгаа. Техник байнга шинэчлэгддэг.

Дээрээс нь мета компаниудын цахим хаягууд нь байнга хиймэл оюун ухаанаар шинэчлэгдэж явдаг учраас техникийн хувьд шинэчлэх шаардлагатай.

Ямар ч байсан бид 2023 оны жилийн эцэст 50.3 хувьтай илрүүлэлтийг ахиулсан. Хуурамч хаяг үүсгэж бусдын нэр хүндэд халдах, хуурамч мэдээлэл тараах гэсэн ийм хэргүүд дээр.

Эрх зүйн хувьд бид боломж байна гэж харж байгаа. Ямар боломж байна гэж харж байгаа вэ гэхээр Харилцаа холбооны зохицуулах хуульдаа интернэт үйлчилгээ үзүүлж байгаа аж ахуйн нэгжүүдийн орж ирж байгаа интернэтийн сүлжээн дээр зохих хэмжээний үнийн дүнтэй олон

улсад хүлээн зөвшөөрөгдсөн, манай хууль тогтоомжид хүлээн зөвшөөрөгдсөн техник, хэрэгсэл тавиад л тэгээд л энэ хуурамч хаягуудыг зохих хуулийнх нь дагуу гомдлоо гаргаад л тэгээд Харилцаа, холбооны зохицуулах хороонд энэ хуурамч хаяг байна гэдгийг тодорхойлоод өгсөн тохиолдолд Монгол Улсад интернэт орчинд үйл ажиллагаа явуулах, үүнийг нь хаах бүрэн боломжтой.

Энэ талаарх танилцуулгыг бид ямаараа дамжуулаад Харилцаа, холбооны зохицуулах хороонд ч өгүүлсэн байгаа.

Тийм учраас бид эрх зүйн хувьд боломжтой гэж үзэж байгаа.

Та хиймэл оюун ухааны талаар ярьж байна. Энэ бол олон улсад гарч эхлэх үе 2023 оны 3 сарын үеэс гарч эхэлсэн. Хиймэл оюун ухаанаар хүнийг дуурайлгаж яриулах.

Энэ үед бид тодорхой зохих түвшний албан тушаалтан, байгууллага руу мэдээллийн танилцуулгуудыг нь хүргүүлсэн. Энэ хиймэл оюун ухаан одоо гадаад хэл дээр ярьдаг, гадаад хэл дээр хүнийг яриулдаг. Бусад орны хэл дээр яриулдаг байсан бол энэ нь одоо монгол хэл дээр ярьж болж байна.

Үүнийг бид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлынхаа хүрээнд судалж үзсэн, туршиж үзсэн. Энэ нь тодорхой төрлийн үнэтэй, тодорхой төрлөөр худалдаж авдаг программ хангамжийг нь худалдаж аваад л, үнэгүй ч байна. Нэг удаагийн хэрэглээний.

Энэ программ хангамжийг нь худалдаж аваад л хийхэд тэгээд л болж байна. Монгол хэл дээр ч болж байна. Үүнийг хэд хэдэн юманд үзэхэд болж байгаа учраас.

Хиймэл оюун ухаанаар хийж байгаа зүйлийг эрх зүйн хувьд нь илрүүлэх, энэ дээр шинжээчийн дүгнэлт томилоод энэ бол биш байна гэдэг шинжилгээний дүгнэлт гаргах боломжтой.

Тийм учраас үүнийг эрх зүйн хувьд нь ч илрүүлж болно, техникийн хувьд нь ч илрүүлж энэ хуурамч байна гэдэг нь гарах боломжтой гэж үзэж байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар:

Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн:

Орж ирж байгаа асуудал бол албан тушаалынхаа томилолттой холбогдож орж ирж байгаа юм байна гэж ойлголоо.

Түүнээс биш сонгуулийн яг өмнөхөн Сонгуулийн ерөнхий хорооны бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт ороод байвал бас хардах сэрдэх тохиолдол гарч болзошгүй юм.

Тэгээд өнөөдрийн энэ бүрэлдэхүүнд өөрчлөлт орж байгаа асуудлыг дэмжиж байна.

Энэ дотор бол бас цагдаагийн байгууллагын удирдлагууд яг албан тушаалаараа орж байгаа юм байна. Тэгээд би бас тодорхой нэг зүйл дээр анхаараач ээ, та нар гэх гээд байгаа юм.

Энэ удаа гишүүдийн тоо нэмэгдсэн. Тэр дотроо 48 хүн жагсаалтаар сонгогдохоор болсон байгаа.

Энэ 48 дотор янз бүрийн юм болно. Олон түмэнд нэр нүүрээ барчихсан, янз бүрийн юманд холбогдож явсан. Тэр битгий хэл хуулиар шийтгэгдэж байсан хүмүүс хүртэл орж ирнэ.

С.Баярцогт жишээлбэл шүүхээр цагаатчихлаа шүү дээ. Ороод л ирнэ шүү дээ. Жагсаалтын ард. Магадгүй дараа нь ч зарим нэг улсууд шүүхээр шийдүүлээд ороод ирэхийг үгүйсгэхийн арга алга байна.

Нөгөө талаар жишээлбэл Ч.Сайханбилэг ороод ирэх бүрэн боломжтой. Яагаад гэвэл шүүхийн шийдвэр гараагүй гээд л ороод ирнэ.

Тэгээд энэ намын жагсаалт гэдэг юм чинь ийм хор уршигтай. Та бүхэн одоо энэ дээр эртнээс сайн бэлтгэлтэй байж, яаж шүүх вэ, тэр бүртгэх дүрэм журмынхаа юмыг сайн тодорхой болгохгүй бол энэ мэтийн нөхдөд шургалах цонхыг нээгээд өгчихсөн байгаа.

Тэгээд энэ дээр л анхааралтай хандмаар байна. Жишээлбэл, шүүх С.Баярцогтыг хэрвээ хэлмэгдүүлсэн гэж байгаа бол яагаад хэлмэгдүүлсэн шүүгч нь ял авахгүй байна. Хэрвээ С.Баярцогт хэлмэгдсэн юм бол тэр хэлмэгдүүлсэн прокурор, хэлмэгдүүлсэн шүүх, хэлмэгдүүлсэн мөрдөгч ял авах ёстой шүү дээ. Бусдыг хэлмэгдүүлснийхээ төлөө. Гэтэл үгүй байна шүү дээ.

Тэгэхээр энэ чинь тоглоом байгаад байна шүү дээ. Гурван шатын шүүгч нар бүгдээрээ хэлмэгдүүлснийхээ төлөө ял авах ёстой. Тэр шалгасан мөрдөгч, прокурорууд ял авах ёстой. Гэтэл тийм юм байхгүй. Зүгээр л цагаандаад өнгөрчхөж байгаа байхгүй юу. Яагаад хэлмэгдүүлсэн улсууд нь зүгээр байгаад байгаа юм. Гэх мэтийн.

Тэгэхээр ер нь энэ жагсаалтын 48 осолтой шүү. Янз бүрийн юмнууд шургална. Янз бүрийн юманд хологдож явсан улсууд шургалах, амьд үлдэх, улс төрд үлдэх ийм нэг нүх сүв болчихсон.

Энэ дээр та бүхэн бас эртнээс сайн бэлтгэлтэй байж, яг ном журмынхаа дагуу бас анхаараарай гэж.

Түрүүн Д.Тогтохсүрэн даргын хэлээд байгаа дээр та нар бас одоо яах вэ хиймэл оюун ухааныг илрүүлэх боломжтой гээд тэгж байна шүү дээ. Гэтэл илрүүлэх гэсээр байтал сонгууль дуусчихвал яах вэ гэдэг асуудал бий шүү.

Тэгэхээр энэ дээр маш анхааралтай хандахгүй бол. Ингээд нөгөөдөх дээр нь янз бүрийн асуудал үүсээд бөөн юм болдог. Нөгөө хүн та нараар шалгуулья гэдэг. Та нар тогтоох гэж байтал сонгуулийн дүн гараад нөгөө хүн өнгөрчхөж болно шүү дээ. Шийдэгдчихэж болно шүү дээ. Асуудал нь.

Тийм учраас хурдан шуурхай байлгах, ер нь сошиалын гүтгэлгийг тухайн үед нь яах вэ.

Одоо зүгээр нэг цагдаагийн байгууллага бол биш байх. Би прокурор дээр байна гэж хараад байгаа юм.

Одоо ингээд хүн гүтгэж байгаа юм. Сошиалаар.

Тэгээд Сүхбаатар дүүрэг ч юм уу, ингээд бид шалгуулах гээд өгч байна шүү дээ.

Прокурор хэрэгсэхгүй болгочхож байгаа байхгүй юу. Илт гүтгэсэн юман дээр л хэрэгсэхгүй болгочхож байгаа юм.

Тэгээд ер нь Монголын нийгэм яагаад сүүлдээ ард түмэн төрийн итгэлцэл байхгүй болж байна гээч. Энэ байхгүй юу. Нэг ч итгэх хүн байхгүй болгоод хаячихсан. Энэ хэвлэл мэдээлэл. Бүгдийг нь гүтгэсээр байгаад итгэх.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? 85.

Т.Сүхболд: Хиймэл оюун ухааны хувьд бид түргэн шуурхай илрүүлж чадна.

Бид нарын одоогийн тооцоолж байгаа, одоогийн шалгаж байгаа техник, тоног төхөөрөмж, одоогийн шалгаж байгаа мэргэжилтэн, шинжээч нар маань 2-оос 3 цагийн дотор л илрүүлнэ. Хамгийн удаандаа. 30 секундийн дотор ч илрүүлэх хүчин чадалтай. Яг одоогийн байдлаар.

Тэгээд л бид 30 секундээс 3 цагийн хооронд илрүүлээд, шалгаад, тэгээд яг л нөгөө гомдол мэдээлэл яаж бүртгэж авдаг вэ, шалгаад л тэр

хуулийнхаа дагуу л ажиллагаа хийнэ. /минут дуусав/

Г.Занданшатар: Гүйцээж хариулах уу? Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн тодруулна.

Ц.Даваасүрэн: Цагдаагийн байгууллага техник, хэрэгслийн хувьд тодруулж чадах юм байна.

Тэгэхдээ ийм хоёр талтай. Одоо ингээд тухайн хүнээс нь шалтгаалаад эрх барьж байгаа, эрх бариагүй ч байдаг юм уу, таньдаг таньдаггүйгээс шалтгаалаад нөлөөлөл оруулахгүй байх юмыг л Сонгуулийн ерөнхий хороо тэр дүрэм журмыг нь сайн зохицуулж өгөх хэрэгтэй байхгүй юу.

Нөгөө цагдаагийн байгууллагын нөхдүүд нь тодруулж байна, тодруулж байна гэсээр. Тэр чинь яг сонгуулийн урд талын өдөр л болно шүү дээ.

Тийм учраас дургүй хүндээ бол тодруулж байна гэсээр байгаад өнгөрөөчих вий. Тийм ээ.

Тийм учраас тэгүүлэхгүй байх. Маш богино хугацаанд үүнийг нь яг шийдвэрлэх боломжуудыг нь харин Та бүгдийг би зохицуулаач ээ л гээд байгаа юм л даа. Техник, хэрэгслийн хувьд бол сайн байна. Тэгэхдээ тэрийгээ ямар нэг нөлөөлөлгүйгээр тэр дүгнэлт нь маш богино хугацаанд гардаг байх чиглэлд анхаараач ээ л гэж байгаа юм.

Г.Занданшатар: Үг хэллээ. Гонгорын Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Сонгуулийн ерөнхий хорооны гишүүдийг дэмжиж байгаа. Энэ явдаг жишгээрээ л явж байгаа байх. Гурван асуулт байна. Сонгуулийн ерөнхий хорооны даргаас.

Нэгдүгээрт, манай гишүүд асуугаад байна. Цахим орчны хуурамч хаягууд, гүтгэлгүүд, тэгээд энэ **AI[Artificial Intelligence]** буюу хиймэл оюун ухаанаар хийж байгаа үйлдлүүдийг цагдаагийн байгууллага хоёр ч гишүүний асуултад хэлж байна шүү дээ.

Бид 30 секундээс 3 цагийн хугацаанд тодруулаад олж чадна.

Сонгууль боллоо. 126 хүн дэвшинэ. Энэ чинь ойролцоогоор тэгээд бараг хэдэн мянган хүн л дэвших нь байна шүү дээ.

Дэвшиж байгаа хүн болгоны асуудлаар тэгээд л тойрог болгон дээр янз янзын юм гарна.

Техникийн чинь боломж, нөхцөл энэ хэдэн зуу, хэдэн мянган хүний асуудлыг тэр доор нь шалгах боломж байгаа юу, хүн хүч чинь хүрэлцэх үү? Нэгдүгээрт.

Үүнийг богино хугацаанд нэмэгдүүлээд сонгуулийн үед хийх боломж, нөхцөл байгаа юу? Ингэж бэлдэж байгаа юу? Нэгдүгээр асуудал.

Хоёрдугаарт, Сая Ц.Даваасүрэн гишүүний асуугаад байгаа, бид чинь Сонгуулийн хуулиар сая уг нь бүртгэлтэй албан ёсны хаягаа өгөх юм билээ. Тийм ээ.

Бүртгэлтэй албан ёсны хаягаас бусад газраас гүтгэлэгтэй холбоотой, юу гэдэг юм янз бүрийн хувиргасан дүрс, хувиргасан дуу, хиймэл оюун ухаанаар хийчихсэн юмыг шалгаж шийдвэрлээд дуустал хамгийн түрүүнд шууд зогсоогоод, хаагаад, тэгээд шалгаж, шийдвэрлэснийхээ дараа нээдэг энэ журмыг зохицуулалтдаа оруулж болох уу? Нэгдүгээр асуулт. Хоёр асуулт. Тийм ээ. Хоёр асуулт.

Гуравдугаарт, Сонгуулийн хууль одоо ингээд 01 сарын 01-нээс мөрдөгдөөд эхэллээ.

Ойлгож байгаагаар ямар нэг бэлэг сэлт, тэгээд л хүнээр дамжуулж өгүүлэх, амлах, хямдралтай үнээр өгөх, сугалаа зохион байгуулах гээд л бүх юм хориотой.

Тэгээд энэ сонгуулийн хуулийг ард нийтэд мэдүүлэх, хүргэх, ойлгуулах, сонгуулийн хууль зөрчиж байгаа мэдээллийг Сонгуулийн ерөнхий хороонд хэрхэн хүргэх, тэгээд ямар шийдвэрүүд хэдий хугацаанд яаж гарах тухай мэдээллийг олон нийтэд хэр түгээж байгаа вэ? П.Дэлгэрнараран дарга аа.

Энэ дээр ямар ажлууд хийгдэж байгаа вэ?

Ер нь ийм сонгуулийн хууль зөрчсөн асуудлууд гарвал хэр хугацаанд яаж шийдэж байгаа вэ? Машин тэрэгний сугалаа явж байна, хурдан морины сугалаа явж байна. Оны өмнө л амжуулцгаалаа л даа.

Яах вэ тэгээд хууль чөлөөтэй байсан болохоор болж л байгаа байх.

Хөөрхий тэгээд буруу ч юу байх вэ?
Хууль нь болж байгаа юм бол.

Одоо ингээд оноос хойш ер нь бид нар ер нь яах ёстой вэ? Ядаж л цагаан сар 2 сарын 10-даар болно.

Би Дарханд байгаа ах дүү нар дээрээ очоод золгохоороо одоо нөгөө бэлэг бэлгийн дээд бэлэн мөнгөө бариад золгохоор сонгогч татсан хэрэгт орох уу, яах вэ? Тийм. Хуульч болгон л янз янзаар тайлбарлах байх.

Тэгэхээр үүнийг энэ сонирхогч этгээдүүд болон ард иргэдэд бас нэг ойлгомжтойгоор тайлбарлах, соён гэгээрүүлэх ажлыг хэрхэн хийж байгаа вэ? Энэ саяын асуултууд байна.

Гуравт нь, энэ хэвлэл мэдээллийн үнэ хөлс тэнгэрт хадчихжээ. Сонгуулийн сурталчилгааны хугацаа 18 хоногт зориулаад л бид нар хуулиа гаргачихсан чинь жишээ нь зарим орон нутгийн телевизүүд хагас жилийнх нь, одоо зөвхөн Улсын Их Хурлын гишүүний ажлаа тайлагнах төлбөр нь 30 сая төгрөг нэхэж байна шүү дээ. Тийм.

Тэгэхээр энэ хэвлэл мэдээллийнхнийг яах ёстой юм бол. Энэ дээр ер нь. Энэ чинь одоо үндсэндээ хөрөнгө мөнгөний бололцоогүй хүмүүс үндсэндээ өөрийгөө таниулах мэдээллээ танилцуулах боломжгүй болж байна л даа. Энэ дээр юу байгаа вэ? Ер нь.

Г.Занданшатар:

П.Дэлгэрнараран дарга. 83. Хуулиа тайлбарлая.

П.Дэлгэрнараран: Г.Дамдинням гишүүний асуултад хариулья.

Би сүүлийн асуултад эхлээд хариулья. Тэгээд нэг дэх, хоёр дахь асуудал манай Цагдаагийн ерөнхий газрын дарга чиг үүргийн дагуу хариулах байх.

Сонгуулийн тухай хуулиар зааж өгсөн, одоо ингээд сонгуулийн жил эхэлж байгаатай холбогдуулаад 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс хойш хэвлэл мэдээллийн байгууллагууд юу хийж болох вэ, юу хийж болохгүй вэ, Улсын Их Хурлын гишүүд одоо бүрэн эрх нь хэрэгжиж байгаа гишүүд юу хийж болох вэ, бас юу хийж болохгүй вэ гэдэг талаар бид арга зүйн зөвлөмж өгч ажиллаж байна.

Маргааш бид хэвлэл мэдээллийн байгууллагуудтай уулзаж хэвлэл мэдээллээр хийж болох зүйл, болохгүй зүйл, энэ асуудлаар хуульд заасан заалтыг хэрэгжүүлэх талаар мэдээлэл, арга зүйн туслалцаа үзүүлж, мэдээлэл хийх ийм ажлуудыг хийнэ.

Ирэх долоо хоногоос Улсын Их Хурлын гишүүддээ бид энэ талаар арга зүйн зөвлөмж өгч ажиллая гэж бодож байна.

Ер нь хуулийг Сонгуулийн ерөнхий хороо тайлбарлахгүй. Гэхдээ хуулийг хэрэгжүүлэх арга зүйн туслалцаа үзүүлж, мэдээллээр хангаж, хуулийг сурталчилж ажиллах үүрэгтэй. Энэ үүргийнхээ дагуу бид салбар чиглэлүүдээр, ялангуяа хэвлэл мэдээллийн байгууллагууд, нэр дэвшигчид гээд, горилогчид гээд 12 дугаар сарын 31-нээр ажлаа өгчихсөн нэлээд олон тооны хүмүүс байна. Энэ

хүмүүс юу хийж болох вэ, юу хийж болохгүй вэ гээд энэ талаар бид арга зүйн зөвлөмжүүдийн боловсруулалт хийж байна.

Ингээд бид маргааш хэвлэл мэдээллийн байгууллагуудаасаа эхлээд зөвлөмжүүдийг хүргүүлээд нийтэд ойлгуулах, сурталчлах ажлуудыг эрчимтэй явуулна гэж хариулья.

Сүүлчийн асуудлыг хариулахад ийм байна. Нэг дэх, хоёр дахь асуудлыг Цагдаагийн ерөнхий газрын дарга, хурандаа Т.Сүхболд хариулна.

Г.Занданшатар: 85.

Т.Сүхболд: Эрхэм гишүүний асуултад хариулья.

Цагдаагийн байгууллага хүн хүчний хувьд гэмт хэрэг, зөрчил, Эрүүгийн хууль зөрчсөн болон Зөрчлийн хууль зөрчсөн, сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг шалгах дээр хүн хүч хүрнэ.

Энэ дээр ажлын хэсэг гарчихсан ажиллаж байгаа. Бүх орон нутагт ажлын хэсэг одоо ингээд 01 сарын 10-ны дотор гараад дуусна. Ерөнхий газрынхаа хэмжээнд ажлын хэсгээ гаргасан. Ингээд ажиллаж байгаа.

Бид гомдол, мэдээллийг цахимаар авч болно, утсаар авч болно, бичгээр авч болно, шууд аман хэлбэрээр очоод өгч болно. Зөвхөн бичгээр авна гэхгүйгээр та хүсвэл цахимаар хүртэл цагдаагийн байгууллагын 102 дугаарын утсанд амаар ч өгч болно. Гомдол, мэдээллийг.

Тэр бичгээр өгсөн, амаар өгсөн, цахимаар өгсөн гэхгүйгээр бүгд шууд тэр үеэсээ авхуулаад л гомдол, мэдээлэлд ороод л шалгагдаж эхэлнэ.

Бид хүн хүчээ тарамдуулахгүйгээр нөхцөл байдлаа харж байгаад ямар ч байсан нэн даруй шалгах, шийдэх ийм ажил руугаа л шилжинэ. Хэрэг зөрчлийн хувьд ингээд шийдчихнэ.

Таны асууж байгаа тэр зогсох, дараа нь нээх гэсэн юм байгаа. Үүнийг энэ журам дээрээ заагаад өгчихсөн байгаа.

Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгааг явуулах, түүнд хяналт тавих журмыг цагдаагийн төв байгууллага болон Харилцаа, холбооны зохицуулах хорооны саналыг үндэслэн Сонгуулийн ерөнхий хороо хамтран баталж мөрдүүлнэ гэж байгаа.

Энэ мөрдөж байгаа журам байгаа. Би гол нь энэ дээр л ажиллана. Энэ журамд өөрчлөлт оруулахгүйгээр цагдаагийн байгууллагын сонгуулийн үеийн хэрэг зөрчлийг шийдэх, гомдол мэдээллийг шийдэх, түргэн шуурхай шийдэх энэ юман дээр хүндрэл учирна.

Та ярьж байна. Одоогоор яг энэ хуурамч хаягийг илрүүлэх чадвар бидэнд байна. Илрүүлэх. Хаах ямар ч бололцоо байхгүй. Бид энд хуурамч хаяг байна, хаая гээд өгөхөд Харилцаа, холбооны зохицуулах хороо цаашаа “Мета” компани руу л явуулна.

Тэр компани нь хаах, хаахгүйгээ 2-оос 3 хоногийн дараа хэлнэ. Заримдаа 15 хоногийн дараа хэлнэ. Заримдаа 3 сар юу ч хэлэхгүй. Тэгээд сонгууль дуусна. Тэр хооронд нь.

Энэ дээр ямар гарц байгаа вэ гээд. Цагдаагийн байгууллага, бид тэгж хараад байгаа юм. Энэ дээр тодорхой төрлийн тоног төхөөрөмжүүд худалдаж аваад л Харилцаа, холбооны зохицуулах хороо шууд хаадаг ийм л юманд хүрчих ёстой. Үүнийг л хийчихвэл энэ ямар ч асуудал байхгүй.

Хуурамч хаяг байна гэдэг мэдээллийг бид цагийн дотор илрүүлж чадна. Таныг гомдол, мэдээлэл гаргаад бид 30 минутын дотор илрүүлж чадна. Жишээлбэл, Т.Сүхболд гэдэг хүний хаяг биш байна, таныг гүтгэж байна гэдгийг бид 30 минутын дотор, 1 минутын дотор илрүүлж чадна.

Тэгээд бид Харилцаа, холбооны зохицуулах хороо руу шууд цахимаар мэдээллийг нь явуулна. Энэ хуурамч хаяг байна. Үүнийг хязгаарлалт тогтоож өгнө үү гэдэг мэдээллийг нь явуулж чадна.

Тэгэхэд таны тухай хуурамч мэдээлэл гарахад бид ойролцоогоор цагаас 3 цагийн хооронд хаах энэ технологийг нь авчихвал хаах бүрэн боломжтой.

Хууль эрх зүйн хувьд нь Харилцаа, холбооны зохицуулах тухай хууль дээрээ байна гэж цагдаагийн байгууллага үзээд танилцуулгаа гаргаад юмаа бэлд.../минут дуусав/

Г.Занданшатар: Гонгорын Дамдинням гишүүн. 1 минут тодруулж асууна.

Г.Дамдинням: Тэгэхээр яах вэ, би цагдаагийн байгууллага бол олчихно, тодруулчихна гээд байна шүү дээ.

Тэгэхээр би П.Дэлгэрнаран даргаас л. Одоо та хэд маань ингээд Их Хурлаар бид нар батлаад гаргачихаар Сонгуулийн ерөнхий хорооны гишүүд болоод гарчих байх.

Тэгээд тэр техникийн боломж нь байгаа бол эрх зүйн хувьд нь журамд чинь хаах тэр эрх зүй нь байгаа юу? Хэвлэлийн эрх чөлөөг зөрчихгүйгээр. Хүнийг илт гүтгээд доромжлоод.

Сая хэлж байна шүү дээ. Шал утгагүй маргаан л даа. Хятад, монголоороо талцаад нэгнийхээ удам судар луу руугаа ороод доромжилцгоогоод эхэлж байна шүү дээ. Удахгүй юу ч болцгоох юм. Мэдэхгүй.

Тэгэхээр үүнийг зогсоож болдог технологи нь байгаа юм байна. Үүнийг нь нэгдүгээрт худалдаад авч болох уу? П.Дэлгэрнаран дарга аа. Сонгуулиас өмнө.

Хоёрдугаарт, үүнийг түр хугацаанд шалгаж дуустал хааж зогсоодог дүрэм журам танайд байна уу? Юу хэрэгтэй байна? Ийм хоёр тодорхой асуултад хариулаач.

Г.Занданшатар: 83.
П.Дэлгэрнаран дарга хариулья.

П.Дэлгэрнаран: Г.Дамдинням гишүүний асуултад нэмж хариулъя.

Ер нь цахим орчинг сурталчилгаанд ашиглах, үүнийг журамлах тухай асуудал хуулиар Харилцаа, холбооны зохицуулах хороо, Сонгуулийн ерөнхий хороо хамтарсан журам батална. Энэ сурталчилгааны журмыг.

Тэгээд энэ журам дээрээ иймэрхүү төрлийн хэрэг, зөрчлүүдийг таслан зогсоох, үүнтэй тэмцэх талаар тодорхой асуудлууд оруулна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа журам байгаа. Тэгэхдээ үүнийг энэ удаагийн сонгуульд зориулж өөрчлөх зайлшгүй шаардлагатай.

Тэгэхээр цаг хугацааны хуваарийн дагуу Харилцаа, холбооны зохицуулах хороо, манай хоёр энэ асуудлыг шийдвэрлэнэ. Тэгээд журам гаргана.

Тэгээд гишүүн таны хэлсэн саяын зарим зөвлөмж, анхааруулгын чанартай зүйлүүдийг бид р энэ дээрээ анхаарч ажиллана.

Ер нь энэ төрлийн хэрэг зөрчилтэй холбоотой.../минут дуусав/

Г.Занданшатар:
Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Шинэ оны мэнд бүгдэд нь хүргэе.

Өнөөдөр он гараад чуулганы анхны өдөр болж байна. Энэ их чухал асуудал бид ярьж байна.

Сонгуулийн 6 сарын 28-ны өдрийг монголчууд, Монголын ард түмэн тэсэн ядан хүлээж байна л даа.

Тэгээд сонгууль яг хуулийн дагуу яваад, засаг төрөө байгуулчхаасай гээд л бүгд л бодож байна.

Ард түмэн бол нэг л өдөр эрхээ эдэлдэг. Төрийн эрх барих. Энэ өдөр нь 6 сарын 28. Тэгээд энэ ажлыг хариуцлагатай сайн хуулийн дагуу хийж гүйцэтгэх үүрэг Та бүхэнд ногдож байна.

Тэгээд ярьдаг л даа. Сонгуульд хэн яаж санал өгөх нь яах вэ. Тэр сонгуулийг яаж тоолж байгаа нь чухал. Хэн тоолох нь. Үүнийг Та бүхэн тоолно.

Тэгэхээр энэ дээр ямар нэгэн хэл амгүй хуулийн дагуу хийх ёстой. Энэ ажлыг төрийн албан хаагчид оролцож явуулна. Энэ уг нь маш хатуу хуулийн заалттай. Төрийн эрхийг хууль бусаар авах гээд. Энэ хууль зүйл ангиар шийтгэгдэж байсан хүн байна уу гэсэн нэг ийм асуулт байна.

Гурван даргаас би гурвуулангаас нь асууя. Сонгуулийн ерөнхий хорооноос. Би тэр хар машинд чинь нэг их итгэхгүй байгаа. Бид нарын ярьж заншсан шиг.

Хуучин тэр чинь баталгаатай, программыг нь баталж өгдөг, баталгаа гаргадаг ийм байдаг байтал 2020 оны сонгуулийг яг тийм баталгаагүй машинаар хийсэн шүү дээ.

Одоо тэрийгээ баталгаажуулаад, бүх юмыг нь

шинэчлээд, найдвартай болгож чадсан уу гэдэг зүйлийг тодруулъя. Сонгуулийн ерөнхий хорооны даргаас.

Улсын бүртгэлээс бас асууя. Улсын бүртгэл бол их хариуцлагагүй байгаа. Удаа дараагийн сонгуулиар. Тэр нэр давхарддаг, нааш цаашаа тухайн юун дээрээ саналаа өгөх боломжгүй болдог энэ тэр гээд ийм асуудлууд бий. Үүнийгээ цэгцэлсэн үү? Энэ талаар найдаж болох уу гэдэг ийм асуулт байна.

Цагдаагаас асууя. Танайх хүн хүчний нөөцтэй гэж ярьж байна. Сая таны хариултыг сонсоод байхад сонгуульд чинь гадна, дотнын байгууллагуудад нөлөөлдөг болчихсон шүү дээ. Гаднаас, дотноос. Тэр хүмүүсийн тархи толгойг удирддаг болчихсон.

Америкийн Нэгдсэн Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд хүртэл нөлөөлж чадаж байна шүү дээ.

Тэгэхээр энэ талаар бас 126 хулгайч ороод ирлээ гэх үү? Одоо 76 хулгайч ороод ирлээ гээд ард түмэн ингэж ярьдаг.

Янз бүрийн юманд холбогдсон улсууд ч гэсэн энэ сонгуулийг тэсэн ядан хүлээж байх шиг байна л даа. Тэгээд энэ талаар яагаад арга хэмжээ авдаггүй юм бэ?

Засгийн газар гэмт хэрэгтэй тэмцэх ажлаа яагаад хийдэггүй юм бэ? Үүнийг Монголын ард түмэн тэсэж ядан хүлээж байна шүү дээ. Энэ ажлаа хийгээсэй гээд хүлээгээд.

Энэ ажлаа хийгээд байсан бол ямар нэгэн байдлаар тэр сошиалд янз бүрийн юм ярихгүй шүү дээ.

Тэгээд бид сонгогчид руугаа л юм яриад байдаг. Тэр сонгогчдоос гаргаж байгаа тэр мэдээллийн дагуу шалгаж энэ хүмүүстээ хариуцлага тооцсон, ийм юмыг нь хийсэн ийм ажил байна уу?

Тэр хүмүүстэй чинь хариуцлага тооцоод хамгийн цаад талын тэр захиалагчийг нь, эздийг нь, тэрийг нь олдог юм байна уу? Наад талын хүмүүс нь зүгээр гар хөл шүү дээ. Энэ талаар ажиллаж байгаа юм байна уу?

Г.Занданшатар:

П.Дэлгэрнарэн. 83. Сонгуулийн ерөнхий хорооны дарга.

П.Дэлгэрнарэн:

Д.Ганбат гишүүний асуултад хариулъя.

Хар машин гэж яриад байгаа. Манай санал тоолох төхөөрөмжийн найдвартай байдал, техникийн бүрэн бүтэн байдлын талаар асууж байна.

Тэгэхээр манай энэ санал тоолох төхөөрөмжийн тоо хүрэлцээг бид 2023 оны төсвийн тодотголд эх үүсвэр тавиулаад, тоо ширхгийн хувьд хүрэлцээтэйгээр авч бэлтгэсэн байгаа. Нөхөн бүрдүүлэлтийг бүгдийг нь хийсэн.

Одоо машинаа тестлэх, ашиглалтад бэлдэх ажил одоогийн байдлаар хийгдэж байна.

Техникийн хувьд бүрэн бүтэн ашиглалтын шаардлага хангаж байгаа асуудал манай төхөөрөмжүүд дээр

асуудал байхгүй. Бүгд ашиглалтын шаардлага хангаж байгаа. Техникийн хувьд бүрэн бүтэн.

Программ хангамжийн хувьд монгол инженерүүд, программистууд маань бүх асуудлаа шийдвэрлэдэг. Энэ асуудлаа одоо батлагдсан хуулийнхаа дагуу саналын хуудасныхаа загварыг хийж батлаад тэгээд программ хангамжийнхаа асуудлыг шийдвэрлэнэ.

Бид нар дээр ямар нэгэн лицензийн болон бусад асуудал байхгүй. Одоо сонгуульд бэлэн гэж хэлж болохоор байна. Одоогийн хувьд.

Төхөөрөмжийн хувьд 2012 оны сонгуулиас хойш ашигласан. Энэ хугацаанд буруу тоолсон, алдаа гарсан тохиолдол байхгүй.

2024 оны Улсын Их Хурлын Сонгуулийн хуульд төхөөрөмжөөр тоолохоос гадна гар тооллогоор хяналтын тооллогыг 100 хувь хийж баталгаажуулна гэж заасан.

Тэгэхээр бид ирэх сонгуульд бүх хэсгийн хороод дээр төхөөрөмжөөр дүнгээ дамжуулсны дараа нэн даруй хяналтын гар тооллогуудыг 100 хувь хийж баталгаажуулах ажил явагдана. Баярлалаа.

Г.Занданшатар: 84.

Д.Дэлгэрсайхан: Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан Д.Ганбат гишүүний асуултад хариулья.

Өнгөрөгч 2020 оны Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар 79 албан бичгээр 293 өргөдөл, гомдол ирсэн байдаг юм.

Энэ дотор ямар нэгэн байдлаар регистрийн дугаар нь давхардсан, өөрөөр хэлбэл нэг хүнийг хоёр удаа бүртгэсэн, эсвэл хэсэг, тойрог дээр мөн давхардуулж бүртгэсэн ийм тохиолдол нэг ч гараагүй.

Ер нь энэ удаагийн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр гурван онцлог зүйл байгаа гэж хариулмаар байна.

Нэгдүгээрх нь, сонгогч өөрийн оршин суугаа хаяг дээр байж байгаа өөрийнхөө болоод бусад хүмүүсийн мэдээлэлтэй танилцах эрхтэй байгаа.

Үүгээр өнөөдөр Улсын бүртгэлийн **burtgel.gov.mn** гэдэг хаяг дээр өнөөдрийг хүртэл ажиллаж байгаа. Яг өнөөдрийн байдлаар 150 мянга гаруй иргэд мэдээлэлтэйгээ энэ хугацаанд танилцсан байна лээ. Танилцах ажиллагаа үргэлжлээд явагдана.

Хоёрдугаарх нь, Сонгуулийн ерөнхий хороонд бүртгэгдсэн нам, эвсэлд нэрийн жагсаалтыг цахимаар хоёр удаа олгохоор байгаа.

Ер нь сонгуулийн нэрийн жагсаалтыг үйлдэх, танилцуулга хүргүүлэх ажил улсын бүртгэлийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг.

Тэгэхээр чиг үүргийг нээлттэй, хяналттай, ил тод байлгах зорилгоор

нэрийн жагсаалтыг хоёр удаа. Өөрөөр хэлбэл өнөөдрөөс эхлээд явж байгаа 6 сарын 28-ны өмнөх, сонгууль болохоос 3 хоногийн өмнөх хүртэлх нь яг энэ мэдээллийг хүргүүлэх юм.

Гуравдугаарх нь, маш онцлог ийм зохицуулалт орсон. Өөрөөр хэлбэл Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн нам, эвсэл, бие даагч, дээрээс нь төрийн бус байгууллагын төлөөлөл сонгуулийн нэрийн жагсаалтыг үйлдэх, танилцуулга хүргүүлэх үйл ажиллагаатай танилцаж болно гэдгийг хуулиар бүр ийм эрх олгогдсон байгаа.

Тэгэхээр энэ дээр сонгуулийн ганц ерөнхий хороо биш Сонгуулийн ерөнхий хороо, улсын бүртгэл, 6 байгууллага гэж ярьдаг. Дээд шүүх, Батлан хамгаалах яам гэх мэт байгууллагуудын мэдээлэлтэй яг яаж энэ нэрийн жагсаалтыг бүр анхнаас нь нөгөө хэсэг дээр оногдохоос авхуулаад хамгийн сүүлд улсын бүртгэлтэй холбоотой өөд болж байгаа хүмүүсийг хасдаг юм уу, биеийн давхцахгүй өгөгдлөө шинээр бүртгүүлж байгаа хүмүүсийг нэмдэг юм уу, энэ бүх өөрчлөлтүүд хэрхэн яаж хийгдэж байгаа талаар танилцуулах үүргийг Улсын бүртгэлийн байгууллага хүлээсэн байгаа.

Тэгэхээр үүнийг бид журамдаа маш тодорхой заасан. Өөрөөр хэлбэл яг хэзээ яаж танилцуулах юм.

Дээрээс нь эрх бүхий байгууллагууд бас энд оролцож ер нь сонгуулийн нэрийн жагсаалт маань хэрхэн яаж үйлдэгддэг энэ процесстой танилцах бололцоогоор хангачихсан гэдгийг хэлмээр байна.

Ер нь өмнөх 2020 оны сонгуулиар харж байхад Улсын бүртгэлийн байгууллагаас 789 бүртгэгч улсын бүртгэлийн байгууллагатай гэрээ хийж ажилласан 2707 итгэмжлэгдсэн ажилтан бас ажилласан байдаг.

Үүгээрээ зөвхөн Улсын бүртгэлийн ерөнхий газар яг энэ ажлыг удирдан зохион байгуулахаас гадна бүх шатны, орон нутаг, дүүрэг дээр байгаа хэсгийн хороод дээр ажиллаж байгаа ажилтнууд маань сонгуулийн нэрийн жагсаалтыг иргэдэд танилцуулах, үүнийгээ эргээд хянах бололцоо нь давхар байдаг. Үүнийг хэлмээр байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн. 85. Цагдаагийн ерөнхий газрын дарга. 85.

Т.Сүхболд: Эрхэм гишүүний асуултад хариулья.

Цагдаагийн байгууллага одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийнхаа дагуу сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн нийт 24 зөрчил дээр зөрчлийн хэрэг нээж ажиллагаа явуулахаар байгаа.

Эрүүгийн хуулийн 14.5-аас 14.9 хүртэл иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажил саад хийх, сонгууль, ард нийтийн санал асуулгад илүү санал өгөх, сонгууль, ард нийтийн санал асуулгад хууль бусаар нөлөөлөх, санал хураалтын дүнг буруу гаргах, сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах, сонгуулийг хууль бусаар явуулах, хуйвалдаан зохион байгуулах гэсэн ийм 5 зүйл анги дээр

тагнуулын байгууллага мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар заасан байгаа гэдгийг танд хэлье.

Цагдаагийн байгууллагын хувьд цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг ч их гарч байгаа, бид ч илрүүлэлтээ ахиулж ажиллаж байгаа.

Таны хэлээд байгаа асуудал дээр би тоон статистик мэдээллээ авчраагүй байна. Ямар ч байсан бидэнд техникийн хувьд ч ахиц гарч байгаа, алба хаагчдын хувьд ч ахиц гарч ажиллаж байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар:

Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууна. 1 минут.

Д.Ганбат: Та бүхэн маань их хариуцлагатай байх ёстой.

2008 оны 07 сарын 01-ний тэр гашуун эмгэнэлтэй өдрийг байнга санах ёстой. Сонгуулиас үүдээд ард түмэн ямар байдалд орж болохыг, энэ талаар та нар бас нэлээн сайн ойлголттой байх хэрэгтэй. Тийм явдал хэрхэвч гаргуулахгүйн тулд маш сайн ажиллах ёстой гэж бодож байна.

Ингээд ер нь амь амьдрал нь болчихсон, баахан хулгай, гэмт хэрэг, ногоон автобусны цавчаа гээд энэ улсууд маш их мөнгөтэй болчихсон. Тэр мөнгөөр хэнийг ч, юуг ч худалдаж авахад бэлэн болчихсон ийм байгаа.

Тэгэхээр энэ юмнуудаа ялгаж салгаж баахан л авлига, албан тушаал, хулгай, ийм юмтай орооцолдсон улсуудтай нэр цэвэр мань мэт шиг хүмүүс л өрсөлдөх нь байна шүү дээ.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Сонгууль шударга явахад бас тодорхой эргэлзээ төрж байгаа.

Хэтэрхий хоёр намын хоорондын хавсадалт, тохирол, тохиролцоо хэрээс хэтэрсэн. Энэ бол ер нь иргэдийн дургүйцлийг хүргэж таарна.

Өнөөдөр Улаанбаатар хотод юу байгаа билээ. Утаа геноцит хийх хэмжээнд хүрчихсэн байна. Ногоон автобусны цавчаа хэрээс хэтэрсэн байна. Улаанбаатар хотын газар олголт, бусад бүх зүйлүүд үнэхээр хамгийн адгийн түвшинд оччихсон. Түгжрэл, энэ бүх зүйл ард иргэдийн дургүйцлийг дээд цэгт нь хүргэчихсэн.

Энэ үед бүсчилсэн тойрог гэдэг асуудлыг хоёр намын хэдхэн дарга хоорондоо шийдсэн.

Дээрээс нь дахиад энэ дотор Улаанбаатар хотод Ардчилсан нам илүү санал авах ёстой байтал тэнд 2 мандат нэмэгдэж байхад тэрийг нь заавал хөдөө рүү тавьж байхад тэнд нь эсэргүүцээд үг хэлж байгаа хүн байхгүй.

Мөн түүнчлэн олон жилийн туршид олон сонгуулийг гурав дахь өдөр явуулж байсан байхад заавал тав дахь өдөр явуулна гэж сонгуулийн ирцийг, ялангуяа залуучуудыг сонгуульд оруулахгүй байх тэр бүх зүйлийг хийж байхад адилхан л чимээгүй л байгаад байдаг.

Ингэж нэг нэгнийхээ үүрд ордог энэ их зүйл чинь ард иргэдийн дургүйцлийг хүргэж байна шүү. Бусад жижиг намууд болон олон намын тогтолцоотой өнөөдрийн Монгол оронд энэ хэтэрхий нэг, хоёрхон нам руу бүх саналыг чирч аваачих энэ тогтолцоо чинь хүмүүсийн дургүйцлийг маш их хүргэж байгаа шүү.

Тэгээд өнөөдөр Д.Ганбат гишүүний хэлдгээр сонгууль будилаантай байна. Өнөөдрийн ийм их ЖДҮ, концесс, тендер, нүүрсний хулгай, төмөр замын хулгай, боловсролын зээлийн сангийн хулгай, ногоон автобусны цавчаа. Тэгээд л энэ их олон хулгайны дараа Монгол Ардын нам бахь байдгаараа л хэт олонх болох юм бол энэ 07 сарын 01-нтэй адил дүйцэхүйц тийм асуудал гарахад эргэлзхээргүй болчхоод байна.

Тийм учраас сонгуулийг зөв зохион байгуулах энэ асуудал дээр эрх баригчдын өөрсдийн дураар гаргасан шийдвэрүүд явж явж өөрсдөө буруугүй. Үүнийг зохион байгуулж байгаа Сонгуулийн ерөнхий хороо, Цагдаагийн ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар дээр бүх буруу болж очуузай л гэж би та гуравт сайн анхааруулж хэлж байгаа юм.

Тийм учраас сонгуулийг зөв болгох тал дээр маш сайн, хариуцлагатай ажиллах ёстой шүү гэдгийг л хэлье.

Тэгээд нэг хэсэг хүмүүс үргэлж л эрх баригчаараа байх ёстой юм шиг, нэг хэсэг хүмүүс нь дандаа сөрөг хүчин байж байх ёстой юм шиг ийм бодлоготой ийм хоёр намын

хуйвалдаан хэрээс хэтэрч байна шүү гэдгийг л энэ дашрамд хэлье дээ.

Г.Занданшатар: Үг хэллээ. Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Шинэ оны мэндийг нийт монголчууддаа хүргэе.

2024 он бол чухал он. Ард түмэн дарга нарт дүнгээ тавьдаг сонгуулийн жил байгаа. Тэгээд тэр ч утгаараа Сонгуулийн ерөнхий хорооны гишүүдийг томилж байгаа асуудал бол бас чухал асуудал.

Тэгээд ер нь шинээр албан тушаалаар томилогдож байгаа гишүүдэд амжилт хүсье. Сонгууль шударга болох ёстой гэдэг зүйлийг эхэнд нь хэлье.

Тэгээд хэд гурван тодруулах асуулт байна.

Сонгогчдын нэрсийн нэгдсэн жагсаалтаас авах нэрсийг яг хэсгийн хороо бүр дээр авах энэ асуудал дээр техникийн боломж эцэслэн шийдэгдсэн үү гэдэг ийм асуулт. Энэ хуульд орсон байгаа заалт байгаа. Тийм ээ.

Тэгээд энэ хүн нэг газар өгчхөөд дахин өөр газар өгөхөөр ороод илэрсэн тохиолдолд хүлээх хариуцлагыг яг микрофон дээр энэ бүртгэлийн дарга нэг хэлээдхээч.

Хоёрдугаарт нь, хар машины асуудал дээр сая хэлчихлээ. Тэгээд бэлэн байгаа гэж ойлгож байна.

Дараа нь 100 хувь гараар тоолох байгаа. Энэ 100 хувь гараар

тоолоход ер нь хэдий хэмжээний хугацаа орно гэж тооцсон бэ? Энэ дээр нэг хэсгийн хороонд 2 мянга орчим сонгогч саналаа өгнө гэж бодохоор өнөөдрийн сонгуулийн хуулийн дагуу өгч байгаа саналын хуудас чинь их ярвигтай болж байгаа шүү дээ. 10 хүн гээд. Энэ дээр хугацааг тооцож үзсэн үү? Үүнийг нэг хэлээд өгөөч.

Тэгээд ер нь сонгуулийнхан сая хэлж л байна.

Ер нь дахиад хэлчихье. Сурталчилгаагаа, сонгуулийн хуулиа одоогоос эхэлж сурталчилгаагаа хийе. Төсөв, санхүү байгаа шүү дээ. Ингэх юм шүү, тэгэх юм шүү гэдэг зүйлийг нэлээн сайн хэлэхгүй бол сонгогчдын боловсрол хэр байгаа билээ, мэдээлэл ямар байгаа билээ. Тийм ээ. Энэ асуудлыг нэлээн сайн хийх ёстой шүү гэдэг асуудлыг тавья.

Сонгуулийн хууль дотор сонгуулийн сурталчилгааны хоногийг бүр 2020 оныхоос 4 хоногоор бууруулчихсан. 14 хоног болгочихсон.

Тэгэхээр миний хувьд Улсын Их Хурлын гишүүдийг ард түмний төлөөлөл, төр, ард түмний хоорондын гүүр гэж үздэг.

Тэгэхээр энэ гүүрээ болгож сонгох гэж байгаа хүмүүсийг чинь тэр ард иргэд маань нэг харж, танилцаж, асууж авах гээд байдаг.

Тэгэхээр 14 хоногийн хугацаа бол бага байгаа. Төв аймаг гэхэд 27 сум, Заамарын Хайлааст тосгон. Ингээд 28. Сэлэнгэ аймаг 17 суман дээр 6 тосгон. Дархан хотод 18 баг дээр нэмэх нь хөдөөгийн 3 сум. Ийм

олон суурин газрууд дээр энэ олон хүмүүс чинь яаж очиж ард иргэддээ мөрийн хөтөлбөрөө танилцуулах вэ?

Энэ дээр гарц гаргалгааны тал дээр Сонгуулийн ерөнхий хороо ер нь бодсон асуудал байна уу? Энэ дээр П.Дэлгэрсайхан дарга нэг байр сууриа илэрхийлээдхээч. Нэг зөвлөмж маягийн. Бүх хүнд ер нь яаж очиж хүрч энэ мөрийн хөтөлбөрийг танилцуулах дээр нэг зүйл хэлээдхээч.

Хоёрт нь, сая иргэд над руу утасдаад асууж байна. Энэ бас танин мэдэхүйн шинж чанартай асуулт байна.

Энэ бэхэн тэмдэглэгээ 100 хувь хийх үү?

Хоёрдугаарх нь, эмч, багш нар орон нутгийн сонгуульд дэвшихэд ер нь боломж нь байгаа юу? Хэдэн хувьтай дэвшиж байгаа вэ гэсэн асуултыг иргэд маань утсаар асууж байна.

Тэгэхээр энэ хоёр дээр бас нэг хариулт өгөөдхөөч.

Г.Занданшатар: 84. Улсын бүртгэлийн газрын дарга.

Д.Дэлгэрсайхан: Улсын бүртгэл, Д.Дэлгэрсайхан Ц.Туваан гишүүний асуултад хариулья.

Сонгуулийн нэрийн жагсаалт нэгдсэн нэг сантай байх талаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж байхад ажлын хэсэг дээр Ц.Туваан гишүүн тантай бас яг энэ талаар ярьж зөвлөж байсан. Өөрөөр

хэлбэл яг нэгдсэн сан буюу аль ч хэсэг дээр, аль ч газар сан маань нэг байх талаар.

Энэ зохион байгуулалт зохицуулалтууд яг энэ байдлаараа хуульд заасныхаа дагуу хийгдэнэ.

Та тоног төхөөрөмжийн бэлэн байдлын талаар асуулаа. Өнгөрсөн жилийн төсвийн тодотголоор бүх улсын бүртгэлийн байгууллагад хэрэглэдэг тоног төхөөрөмжийн багц буюу компьютер, принтер, хурууны хээ уншигчийг бүрэн худалдан авах ажиллагаа нь хийж дууссан.

Одоо энэ тоног төхөөрөмжүүдийг турших, хэвийн ажиллагаанд нь оруулах ажиллагаа хийгдэж байна.

Нэг асуудал нь зөвхөн сүлжээний асуудал байгаа. Зарим газруудад сүлжээ ажиллахгүй, гар утас ч ажиллахгүй тохиолдол гарах бас магадлалтай.

Ийм учраас бид ганц тоног төхөөрөмж гэхгүйгээр бас программ хангамжийн хувьд энэ оффлайн горимд. Өөрөөр хэлбэл нэгдсэн нэг сан байж байгаа учраас мэдээллийг тодорхой хугацаанд наашаага шийдэж ажилладаг байдлаар программын хувьд зохион байгуулалтыг энд хийж байгаа гэдгийг танд хэлмээр байна.

Өөрөөр хэлбэл ямар ч газар, ямар ч сонгогч очсон тухайн сонгогчийг таньж, баталгаажуулах давхардуулахгүй байх зохион байгуулалтыг техник хангамж болоод

программ хангамжийн хувьд хийж байгаа гэдгийг хэлмээр байна.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан. П.Дэлгэрнараран дарга. 83.

П.Дэлгэрнараран: Ц.Туваан гишүүний асуултад хариулъя.

2024 оны Улсын Их Хурлын сонгуульд төхөөрөмжөөр саналын дүнг дамжуулаад тэгээд дараа нь тэр даруй гар тооллогыг эхлүүлнэ гэж заасан байгаа.

Тэгэхээр гар тооллогыг тухайн хэсгийн хорооны гишүүд, улс төрийн намын ажиглагчид, хэвлэл мэдээллийн байгууллагуудын хяналт доор тухайн хэсгийн хороонд байрлуулсан камерт уншигдахаар гар тооллогыг зохион байгуулна.

Уг камер гар тооллогын явж байгаа процессыг бичиж баталгаажуулна. Тэгээд дараа нь камер тэр гар тооллогын дүнг бичиж баталгаажуулаад хадгалагдана. Шаардлагатай гэж үзвэл иргэд, сонгогчдын гомдлоор, сонгуулийн субъектүүдийн гомдлоор тухайн камерыг дахин шалгаж хэрэг зөрчилтэй холбоотой асуудлыг шалгах бүрэн бололцоотой.

Гар тооллогын хувьд 100 хувь тоолно.

2021 оны Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг бүгдийг нь камер тавьж 100 хувь гараар тоолж хяналтын тооллого хийж баталгаажуулсан. Энд төхөөрөмжийн дүнг, гар тооллогын дүнг

хоёр зөрөөгүй. Ер нь зөрөх ёсгүй гэж бид үзэж байгаа. Угаасаа зөрөх ёсгүй.

Тэгэхээр гар тооллогыг бид 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийнхаар тооцож үзэх юм бол бид 22.00 цагт хэсгийн хороод хаагаад, цахимаар дүн дамжаад тэгээд түүний дараагаар гар тооллого хийхэд тэр шөнөдөө бид хийгээд өглөөний 6 цаг, 8 цаг гэхэд ер нь дүнгүүд улсын хэмжээнд урьдчилсан байдлаар нэгтгэгдэж байсан.

Энэ удаад Ц.Туваан гишүүний хэлж байгаа тэр саналын хуудас бол өөр, мандатын тоо олон. Үүнийг гараар тоолоход бас жаахан ажиллагаа ихтэй болно. Тэгэхдээ хугацааны хувьд жаахан урт болно гэсэн үг.

Тэгэхдээ энэ бол одоо хэд хоногоор гэдэг юм уу, хэдэн өдрөөр сунжрахаар удаан хугацаа зарцуулагдахгүй. Санал хураалтын дараагийн өдөр гэхэд ерөнхийдөө урьдчилсан дүнгээр гараад ирэх байх гэж бид төсөөлж байна. Энд хугацаа гайгүй орох байх.

Харин бид гар тооллогын хяналтыг илүү их сайн болгоно гэж бид бодож байгаа. Хэвлэл мэдээлэл, иргэдийн хяналтыг тавиулна. Намуудын хяналтыг нэлээн сайн байлгахаар бид төлөвлөж байгаа.

Сурталчилгааны хувьд 14 хоног гээд хэвлэл мэдээллээр яваад байгаа. Хуульдаа 18 хоног байгаа юм. 18 хоног олгогдож байгаа.

Тэгэхдээ яах вэ хамгийн сүүлчийн сурталчилгааны хаасан өдрийг хасвал 17 хоног оногдож

байгаа. Тойрог том болсон. Мандатын тоо олон болсон. Газар нутгийн хэмжээ нэлээд том болно.

Тэгэхээр энд бид нэгэнт хуульд заачихсан, хуульчлаад тогтоочихсон учраас би үүнийг ингэх ёстой гэж хэлэх зүйл алга. Зүгээр зөвлөгөө маягаар хэлэхэд цахим сурталчилгааны үүрэг роль их болно гэж үзэж байгаа.

Цахим сурталчилгаа илүү үр дүнгээ өгнө. Гэхдээ гол гол сонгогчидтой газруудаараа нэр дэвшигчид маань өөрөө биечлэн явж олон сонгогчидтой газруудаараа ядахдаа өөрсдөө биечлэн явах болов уу гэж бид төсөөлж байгаагаа хэлье.

Бэхэн тэмдэглэгээг 100 хувь хийнэ. Хуульд заасан. Бэхэн тэмдэглэгээг энэ удаад хийнэ. Яагаад гэвэл бэхэн тэмдэглэгээг бид саналыг давтан... /минут дуусав/

Г.Занданшатар:

П.Дэлгэрнаран дарга гүйцээгээд товч тодорхой хариулчих. 1 минут. 83. Пүрэвээгийн Дэлгэрнаран.

П.Дэлгэрнаран:

Бэхэн тэмдэглэгээг 100 хувь хийнэ. Энэ хуульд тусгагдсан.

Тэгэхээр бид бэхэн тэмдэглэгээ хийхийг бас дэмжиж байгаа. Яагаад гэвэл энэ бол нэг сонгогч давтан дахин санал өгөхийг хязгаарлах бас нэг сайн арга гэж үзэж байгаа учраас. Бэхэн тэмдэглэгээ нэгэнт хуульчлагдсан учраас 100 хувь хийнэ. Энэ бэлтгэл ажлыг бид хийж байна.

Хамгийн сүүлд багш, эмч нар орон нутгийн сонгуульд нэр дэвших боломж байна уу гэж.

Монгол Улсын иргэн ямар ажил төрөл эрхэлж байгаа, нас, хүйсээсээ үл шалтгаалаад сонгогдох эрхээ бүрэн эдлэх боломжтой.

Тийм учраас эмч, багш нарын хувьд орон нутгийн сонгуульд тухайн сонгуулийн хуулийн тавигдсан шаардлагын дагуу нэр дэвших бүрэн боломжтой.

Тэгээд эмч, багш нараас хэдий хэмжээний хүн нэр дэвших боломжтой.../минут дуусав/

Г.Занданшатар: Санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд. Санал хураалтад бэлд.

Улсын Их Хурлын гишүүн Цэдэндамбын Цэрэнпунцаг, Балжиннямын Баярсайхан нарын урилгаар Завхан аймгийн Цэцэн-Уул сумын иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрхэм хүндэт Завханчууд Цэцэн-Уулчууддаа сайн сайхныг хүсэн ерөөе. Шинэ оны мэнд дэвшүүлье.

Эхлээд томилох санал хураалт явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108.2-т заасны дагуу нэгдсэн хуралдаанд эрх бүхий албан тушаалтны санал, холбогдох Байнгын

хорооны санал, дүгнэлтийг үндэслэн нууц санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх томилох, чөлөөлөх саналыг дэмжсэн бол тухайн тогтоол баталсанд тооцно гэж заасны дагуу санал хураалтыг нууцаар явуулна.

Эхлээд томилох санал хураалтыг явуулна.

Дагвадоржийн Дэлгэрсайханыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Нууц санал хураалт явуулахад бэлдэнэ. Бэлэн болсон уу?

80.0 хувиар дэмжсэн.

Эхлээд томилох санал хураалт явж байгаа.

Төмөрбаатарын Сүхболдыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

80.0 хувийн саналаар санал дэмжье.

Одоо чөлөөлөх санал хураалт явуулна.

Бямбажавын Ганбатыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулна. /алх цохив/

82.5 хувийн саналаар саналыг дэмжлээ.

Жамсранжавын Болдыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулъя. /алх цохив/

82.5 хувийн саналаар саналыг дэмжлээ.

Томилох, чөлөөлөх саналуудыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанд тооцлоо. /алх цохив/

Тогтоол батлагдлаа. Тогтоолыг эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Тогтоолын эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Ингээд сонгуулийн жил эхэлж байна. Гишүүд чуулганы хуралдаандаа идэвхтэй оролцоно.

Зарим нэг гишүүд чөлөө зөвшөөрөл авахгүйгээр гадаад дотоод явж чуулганы болон Байнгын хороодын хуралдааныг саатуулах асуудлыг олон нийтэд мэдээлнэ шүү.

П.Дэлгэрсайхан дарга, Сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэлийн дэд хорооны дарга Жамбын Батсуурь гишүүн ажлаа хиймээр байна.

Тэр сонгогчдын нэрсийн жагсаалт бүртгэлийн асуудлаараа нэг дэд ажлын хэсэг оруулсан. Тогтоол энэ

тэр оруулж ирж шалгана гэсэн. Сонгуулийн өмнө тэр маргаангүй болгох асуудлуудаа.

Тийм учраас Ардчилсан намаас энэ Сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэлийн дэд хорооны даргаар томилсон шүү дээ.

Одоо ажлаа хийж, сүүлд нь элдэв маргаан, хэл амгүй байхаар сонгогчдын нэрсийн жагсаалтаа баталгаажуулах ажлыг Улсын бүртгэлийн газартай хамтарч зохион байгуул.

Сая Сербийн сонгуульд тэр хиймэл оюун ухаан “deepfake”-ийг зохицуулна л гээд байгаа. Яг сонгууль болохоос нэг хоногийн өмнө хуурамч аудио бичлэг барууны намынхаа даргын бичлэгийг, пивоны үнийг хоёр дахин нэмнэ гэсэн бичлэгийг нь тавиад, тэгээд нөгөөдүүл нь сонгуульд ялагдчихсан шүү дээ.

Тэгээд энэ чинь яг нөгөө залруулах бололцоо энэ тэр олгохгүй. Сонгуулийн өмнөх өдөр.

Одоо Америкийн сонгуульд хиймэл оюун ухаан “deepfake” маш их ашиглагдаж байна.

Тийм учраас үүнийг бас. Тэгээд “Facebook”-тэй бид улаан шугам нээж харилцаж чадаж байна уу. Ийм юмнуудыг.

Тэгээд тэр Цахим сүлжээний тухай хуулийг хориг тавьчихсан. Тэр бол зайлшгүй байж филтер энэ тэрийн систем явахгүй бас дэлхий нийтэд сонгууль төдийгүй улс төр, нийгмийн тавцанд энэ хиймэл оюун ухаан

ашигласан, хиймэл оюун ухаанаар удирдсан нийгмийн сүлжээ хамгийн том эрсдэл болж байна гэж дүгнэж байгаа шүү.

Ийм учраас энэ дээр холбогдох хууль эрх зүйн орчин яаралтай шаардлагатай бол П.Дэлгэрнаран дарга

олон улсын туршлага судлаад оруулж ирэх хэрэгтэй.

Ингээд тогтоолын эцсийн найруулгыг сонссон. Баталлаа.

Та бүхэнд ажлын амжилт хүсье.

Дараагийн асуудалд орно.

Хоёр.Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна.

2012 оны 12 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл уг асуудлаар ажлын 5 хоногийн завсарлага авсан.

Завсарлагын хугацаа дууссан байна. /алх цохив/

Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулж О.Цогтгэрэл дарга үг хэлэх үү? О.Цогтгэрэл дарга өөрөө алга байна.

Ажлын хэсгийн гишүүдийг оруулья.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор үргэлжлүүлж санал хураалт явуулна.

Эхний 10 саналыг санал хураалт явуулаад зогссон байгаа. Нийт 54 санал хураалттай.

Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэлэлцэнэ. 10 дахь санал чинь уначихсан. Тийм ээ. Одоо 11 дэх саналаас явна.

11.Төслийн 2.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “байгуулж болно” гэснийг “байгуулна” гэж өөрчилж, мөн зүйлийн 6 дахь хэсгийн “Засаг даргын орлогч” гэсний дараа “, эсхүл тухайн аймаг, дүүргийн Засаг даргын ажлын албаны хуулийн асуудал хариуцсан нэгжийн дарга” гэж, 9 дэх хэсгийн “байгууллага,” гэсний дараа “сум дахь хууль зүйн хорооны нарийн бичгийн даргын үүргийг тухайн сумын хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “олон улсын байгууллагын төлөөлөл,” гэснийг, мөн зүйлийн 5 дахь хэсгийн “аймаг, дүүрэг,” гэснийг, 10 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн дараах байгууллагын удирдах албан тушаалтнаас бүрдэнэ:

2.1.нутгийн өөрөө удирдах байгууллагын ажлын алба;

2.2.аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, хэлтэс;

2.3.аймаг, дүүргийн боловсролын газар, хэлтэс;

2.4.аймгийн эрүүл мэндийн газар, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв;

2.5.аймаг, дүүргийн хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний газар, хэлтэс;

2.6.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын алба;

2.7.Засаг даргын ажлын албаны хуулийн асуудал хариуцсан нэгж;

2.8.аймаг, дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтэс;

2.9.аймаг, нийслэл, дүүрэг дэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс;

2.10.аймаг, дүүргийн прокурорын газар;

2.11.шүүхийн тамгын газар.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 2.12 дугаар зүйлийн 1.2 дахь заалтын “хүчирхийлэл үйлдсэн этгээдийг тогтоох зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлэхээс өмнө” гэснийг хасаж, мөн зүйлийн 1.3 дахь заалтын “зөвлөгөө,” гэсний дараа “эрх зүйн туслалцаа, мэдээлэл өгөх, гэж, мөн заалтын “саналаа хэлэх,” гэсний дараа “хүсэлт гаргах” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 1.7 дахь заалтын “газарт нь” гэснийг “газар, тусгай өрөөнд” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Төслийн 3.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “ашиглах,” гэсний дараа “хүүхдийг үл хайхрах,” гэж нэмж, мөн зүйлийн 8 дахь хэсгийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 8 дахь хэсэг нэмэх:

“8.Хүүхдийн дэргэд согтууруулах ундаа хэрэглэх, эсхүл хэрэглэсэн үедээ хүүхдийн амьдарч, суралцаж байгаа орчин, орон байранд нэвтэрснийг хүүхдийг эрсдэлт нөхцөлд оруулсантай адилтгаж үзэж болно.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Төслийн 3.1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9 дэх хэсэг нэмэх:

“9.Эцэг, эх хүүхдээ эрсдэлт нөхцөлд орж болзошгүй соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолтод оролцуулах тохиолдолд гэнэтийн ослын даатгалд даатгуулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Үүнийг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. /алх цохив/

Энэ чинь хурдан морины хүүхэд заавал эцэг, эх нь биш уяач нь даатгуулдаг. Уралдаан, тэмцээнд оролцож байгаа хүмүүс, тэр зохион байгуулагч нь даатгуулж болно. Заавал эцэг, эхийг.

Хурдан морины хүүхдүүдийг эцэг, эхийг нь даатга гэх нь байна шүү дээ. Тийм. Тэгэхдээ энэ эцэг, эхийг нь даатгана гэж байхгүй л дээ.

15.Төслийн 3.2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 2.7 дахь заалт, 9, 10,11 дэх хэсгийг тус тус нэмэх:

“2.7.хичээлийн жилийн турш хүүхэд эрсдэлт нөхцөлд байгаа эсэхийг үнэлэх, зөвлөгөө өгөх, хүүхэд бүрийн нийгэм, сэтгэл зүйн асуудлыг илрүүлэх, тандан судлах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх;

9.Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлагыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон боловсролын

асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

10.Боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвд суралцаж байгаа хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдлын тандалт судалгааг гурван жил тутам Боловсролын ерөнхий хуулийн 17.2-т заасан байгууллагаар хийлгүүлнэ.

11.Боловсролын ерөнхий хуулийн 40.2.8-д заасан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн төлөөллийн байгууллага хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын төлөвлөгөөтэй байна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.

Хийлгүүлнэ гэдэг одоо ямар үг байна аа? Хийлгүүлнэ гэж ямар үг байна.

11.2-т заасан байгууллага хийнэ л гэж баймаар. Санал хураалт. /алх цохив/

Энэ Тамгын газар найруулгыг нь сайн хяна. За юу. Хууль зүйн техникийн хувьд ийм хөндлөнгийн мэтээр үг бичүүлдэг.

68.4 хувиар дэмжигдлээ.

16.Төслийн 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.11 дэх заалт, 4.5.2 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2.11 дэх заалтыг 2.12, 2.13 дахь заалт болгох:

“1.Боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төв, сүм хийд, шашны

сургууль нь хүүхэд хамгааллын бодлого, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна.

2.12.хүүхэд тодорхойгүй шалтгаанаар хичээлдээ ирээгүй тохиолдолд гэр бүл, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нэн даруй мэдэгдэх;

2.13.хүүхэд эрсдэлт нөхцөлд өртсөн талаар мэдсэн, таамагласан, илрүүлсэн бол харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд мэдэгдэх.

4.5.2.сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг үзүүлэх, хүүхдийн төлөвшилд нөлөөлөх сургалт, үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамт хамруулах.”

Санал гаргасан Ажлын хэсэг.

Гонгорын Дамдинням гишүүн. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлнэ. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн. Тасаллаа. /алх цохив/

Үг хэл. Г.Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Үгээсээ өмнө. Түүрүүн дарга аа, та намайг сонгуулийн хууль зөрчсөн гээд байсан. Тэрийгээ залруулаарай. Хэдийгээр тоглоом ч гэсэн энэ чинь бас сонгуулийн жил эхэлчихсэн. Түвэгтэй юм болно шүү. Ард түмэн харж байгаа. Та бид нарын ажлын дундаа тоглож ярьж байгаа.

Г.Занданшатар: Энэ асуудалтай холбоогүй юм байна. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Яах вэ, хүүхдийн асуудал ингээд сүүлийн үед яриад ингэж байгаа нь зөв л дөө.

Тэгэхдээ бид нэг л анхаармаар байгаа юм. Ерөөсөө бид ирээдүйн эцэг, эх бэлтгэх чиглэлд нь их сайн анхаарч өгмөөр байгаа юм. Хүүхдүүдийг.

Өнөөдрийн бидний алдаа бол ерөөсөө хүн болгох, эх оронч хүмүүжил суулгах, нийтэч үзэлтэй байлгах гэдэг юмыг ерөөсөө тэр хүүхэд байхад нь хийж өгөх ёстой юм л даа. Хүүхдээ хайрлах, хамгаалах.

Тийм юм хийгээгүй хүнд хичнээн сайхан хууль гаргаад тэр хууль сахихгүй ээ, мөрдөхгүй ээ.

Бид хуулиар хаанаа ч дутаагүй. Өчнөөн олон хууль, баримт бичиг, хөтөлбөрүүд зөндөө бий. Гол нь наадахыг чинь хэрэгжүүлдэг ёс суртахуун, төлөвшил байхгүй байгаа.

Тийм учраас бидний анхаарах ёстой юм бол ерөөсөө л боловсролынхоо тогтолцооны тэр хүүхдэд өгч байгаа агуулгыг өөрчлөх ёстой. Хүн болгон ёстой. Эх оронч болгох ёстой. Нэгдмэл үзэлтэй байх ёстой.

Бүгдээрээ хувиа хичээсэн байгаа байхгүй юу. Монголчуудын хамгийн том алдаа бол нэгдмэл эрх ашиг гэж байхгүй. Би, би гэж явсаар байгаад энэ улс орон чинь өнөөдөр ийм болчихоод байна шүү дээ.

Тийм учраас би энэ хууль гаргаад хэрэгжих хөрс маш муу гэж харж байна. Тийм учраас ер нь гол анхаарах ёстой юм бол харин энэ хүүхдүүдийг яг өдий байхад нь ирээдүйн сайн эцэг, эх байх чиглэлд юмнуудыг нь хуульд харин сайн хийж өгөх хэрэгтэй шүү л гэж хэлмээр байгаа юм.

Г.Занданшатар: Гишүүд үг хэллээ.

Г.Дамдинням гишүүн цагаан сараар хамаатан саднуудтайгаа мөнгө барьж золгож болох уу, болохгүй гэж асуусныг болохгүй гэсэн болохоос. Цагаан сар болоогүй байгаа юм чинь таныг хууль зөрчсөн гэж би хэлээгүй шүү дээ. Залруулга биш.

Тэр чинь цагаан сараар, болоогүй байгаа үйл явдалд мөнгө тарааж болох уу, үгүй юу гэж, мөнгө барьж золгож болох уу гэдэг чинь хууль зүйн хувьд буруу асуулт байна л гэж би тодотгосон юм.

Ингээд санал хураалт явуулья.
/алх цохив/

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Төслийн 3.2 дугаар зүйлийн 4.5.1 дэх заалтын “сануулах” гэсний дараа “зөвлөгөө өгөх, хохирогч суралцагчаас уучлалт гуйлгуулах” гэж, мөн зүйлийн 5.5 дахь заалтын “эрсдэлд нөхцөлд” гэсний өмнө “боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн сургалтын хөтөлбөрт” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “Боловсролын сургалтын

байгууллагын удирдлага, хүүхдийн эрх, хамгааллын үйлчилгээ үзүүлэх нэгж” гэснийг “Боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төв” гэж, мөн хэсгийн “мэдээллийн мөрөөр нэн даруй хяналт шалгалт явуулж” гэснийг “мэдээллийг хүлээн авч,” гэж, мөн зүйлийн 4.5 дахь заалтын “суралцагчийг сургалт, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд хамруулах,” гэснийг “хүүхдэд” гэж, мөн зүйлийн 6 дахь хэсгийн “Шашны байгууллага /сургууль/-ын дэргэдэх” гэснийг “Боловсролын сургалтын байгууллага, сүм хийдийн” гэж, 8 дахь хэсгийн “Шашны байгууллага /сургууль/-д суралцах хүүхэд, түүний гэр бүлд” гэснийг “Боловсролын сургалтын байгууллага, сүм хийдийн орчны аюулгүй байдалд” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 4.4 дэх заалтын “, удаа дараа хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртсөн суралцагч, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрснөөр өөр бүлэг, сургууль руу шилжүүлэх” гэснийг, мөн зүйлийн 4.5.3, 4.5.4 дэх дэд заалт, 4.6, 4.7, 5.1, 5.3, 5.6 дахь заалт, 9 дэх хэсгийг тус тус хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Ажлын хэсгийн ахлагч нь Ц.Идэрбат гишүүн билүү? Тийм ээ. Шашны байгууллага, сүм хийд л гэж орж ирээд байх юм.

71.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Төслийн 3.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “байгууллага” гэсний дараа “эрсдэлд нөхцөлд байгаа” гэж

нэмж, мөн зүйлийн 5.1, 5.3 дахь заалт, 6 дахь хэсгийг тус тус хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Энэ “эрсдэлт нөхцөл” юм уу? “Эрсдэлд нөхцөлд” гэж. Аан..? Энэ бусад бүх тохиолдолд тэгж давтагдаад байгаа юм. Өмнөх өгүүлбэр нь өөр байгаа юм уу? Үүнийг нягталж үзээрэй. Тамгын газар.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

71.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ Х.Булгантуяа сайд чинь бас заримдаа баруун аймаг явахаар тэр хавийнх болчихоод байдаг билүү.

19.Төслийн 3.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа” гэснийг “хүүхдэд хортой агуулга” гэж өөрчилж, мөн зүйлийн 3-11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3-13 дахь хэсэг болгох:

“3.Хүн, хуулийн этгээд хүүхдийг цахимаар урхидах, дээрэлхэх, дарамтлахыг хориглоно.

4.Хүн, хуулийн этгээд хүүхдийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон, эсхүл хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийн зураг, дуу, дуу-дүрсний бичлэг агуулсан контент, мэдээ, мэдээлэл, бүтээлийг олон нийтэд түгээхийг хориглоно.

5.Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчны үйлчилгээ

эрхлэгч өөрийн үйлчилгээнд хориотой агуулгыг түгээхгүй байх, хүүхдэд хортой агуулгыг хянах, хязгаарлах, хаах арга хэмжээ авах үүрэгтэй.

6.Интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэрийн дагуу цахим орчинд түгээсэн хүүхдэд хортой болон хориотой агуулгыг өөрийн сүлжээнд хязгаарлалт хийх технологийн арга хэмжээг авна.

7.Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч контент, бүтээлийг олон нийтэд түгээхийн өмнө насны ангиллын тэмдэглэгээг байршуулна.

8.Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч хүүхдийг хориотой, хүүхдэд хортой агуулгаас хамгаалах зорилгоор насанд хүрэгчдэд зориулсан тохиргоог идэвхжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

9.Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч Харилцаа холбооны зохицуулах хорооны мэдэгдэлд заасан хориотой, хүүхдэд хортой агуулгыг өөрийн үйлчилгээнд хязгаарлах, хаах үүрэгтэй.

10.Хүн, хуулийн этгээд хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчинд хориотой агуулга түгээснээс хүүхдийн эрх зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй гэж үзвэл гомдлоо хүүхдийн эрхийн улсын байцаагч, цагдаагийн байгууллагад гаргаж, шийдвэрлүүлнэ.

11.Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмыг цахим хөгжил,

харилцаа холбооны, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль, зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

12.Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллана.

13.Энэ зүйлийн 12-т заасан орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар батална.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Интернэт үйлчилгээ үзүүлэгчдийн филтер тавих үүрэгтэй болж зохицуулагдаж байна шүү дээ.

20.Төслийн 3.4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараах тайлбар хэсэг нэмэх:

“Тайлбар:Энэ зүйлд заасан “цахим орчны үйлчилгээ эрхлэгч” гэж цахим хуудас, цахим хэрэглүүр /аппликэйшн/, платформ, цахим орчин ашиглаж контент, бүтээлийг олон нийтэд хүргэх үйлчилгээ үзүүлэгч этгээдийг ойлгоно.

Энэ зүйлд заасан “цахимаар урхидах” гэж хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд уруу татах зорилгоор цахим

сүлжээ ашиглан хүүхэдтэй харилцаа тогтоохыг хэлнэ.

Энэ зүйлд заасан “цахимаар дээрэлхэх” гэж цахим орчинд хүүхдийг дээрэлхэж, гадуурхсан, айлган сүрдүүлсэн, доромжилсон зүй бус агуулга бүхий мэдээ, мэдээллийг өөрт нь болон бусдад түгээхийг хэлнэ.

Энэ зүйлд заасан “цахимаар дарамтлах” гэж хүүхдийг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг шаардаж өөрт нь, түүний ойр дотны хүний эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар цахим сүлжээнд сүрдүүлэхийг хэлнэ.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ цахимаар урхидах гэдэг дээр зөвхөн хүүхэд биш энэ мөрийтэй тоглоомд хүнийг бүр тодорхой зорилготой урхидаж, уруу татаж оруулдаг ийм гэмт бүлэглэл саяхан Хятадад. Хятад бүр маш том тэмцлийн ажиллагаа өрнүүлж байгаа шүү дээ. Хүүхэд, залуучуудыг цахимаар урхиддаг. Бүр тодорхой зорилготойгоор.

Үүнийг яам бас анхаармаар юм билээ.

22.Төслийн 3.6 дугаар зүйлийн 9, 10 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “оролцуулахдаа” гэсний дараа “хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах,” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн

“дасгалжуулагч,” гэсний дараа “зохион байгуулагч” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 5.2 дахь заалтын “хамруулж, өсөлт, хөгжлийн талаар дүгнэлт гаргуулах” гэснийг “хамруулах” гэж өөрчлөн мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5, 6 дахь хэсэг, тайлбар хэсгийг тус тус нэмэх:

“5.Хүүхдийг оршин суугаа газраас өөр газарт 24 цагаас дээш хугацаагаар соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, спортын тэмцээн, бусад арга хэмжээнд оролцуулахад 15 хүртэлх хүүхэд тутамд нэг багш, дасгалжуулагч ажиллаж, хүүхдийн аюулгүй байдлыг хангана.

6.Үндэсний их баяр наадмын тухай хуульд зааснаас бусад хурдан морины уралдааныг зохион байгуулах тохиолдолд зохион байгуулагч нь хурдан морины уралдааны бэлтгэлийн үе эхлэхээс өмнө харьяа сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэж, бүртгүүлнэ.

Тайлбар:Энэ зүйлд заасан “уяач” гэдгийг хурдан морины уралдаанд уралдаж байгаа морины өмчлөгчийг ойлгоно.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Энэ санал дэмжигдсэнгүй. Энэ тэгэхдээ өмчлөгч гэдэг дээр нь тэгчихэв үү. Уяачийг өмчлөгч гэж ойлгож болохгүй л дээ. За яах вэ. Уначихлаа.

21.Төслийн 3.5 дугаар зүйлийн 2, 6 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмэх:

“5.Сум, дүүргийн Засаг дарга, хүүхдийн эрхийн улсын байцаагч худалдаа, үйлчилгээний газар, боловсролын сургалтын байгууллагаас гадуурх сургалтын ажил эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хүүхдийн эрх зөрчигдөж байгаа эсэхэд хяналт тавьж, хүүхдийг эрсдэлт нөхцөлд оруулсан бол уг үйл ажиллагааг хязгаарлах, зогсоох арга хэмжээ авна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

23.Төслийн 3.7 дугаар зүйлийн гарчгийн “онцгой нөхцөл байдлын нөхцөлд байгаа” гэснийг “гамшгийн онцгой нөхцөл байдлын” гэж, мөн зүйлийн “онцгой” гэснийг “гамшгийн онцгой нөхцөл” гэж тохиолдол бүрд өөрчилж, мөн зүйлийн 6, 7 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмэх:

“5.Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед хүүхдийг насанд хүрсэн хүнд харгалзуулалгүйгээр орхих, хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахаас бусад тохиолдолд хүүхдийг байгаа газраас нь авч явах, тээвэрлэхийг хориглоно.”

Санал гаргасан Ажлын хэсэг.

Үүнийг Байнгын хороо тэр Гамшгийн тухай хууль, Онцгой байдлын хууль энэ тэрийн чинь заалтуудтайгаа уялдуулж, эсвэл эшлэх юм уу, силк хийж ингэж яахгүй бол энэ чинь үг, үсэг нь зөрөөд байна шүү.

Санал хураалт. /алх цохив/

55.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

24.Төслийн 3.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил. Энэ санал гаргагч этгээд өөрөө байхгүй байгаа тул санал хураалт явуулж унагаасугай. /алх цохив/

42.1 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

25.Төслийн 3.8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “нас,” гэсний дараа “хүйс,” гэж нэмж, мөн хэсгийн “таатай орчинд” гэснийг “тусгай өрөөнд” гэж өөрчилж, мөн зүйлийн 7 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Төслийн “ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ” гэснийг “ХОЁРДУГААР БҮЛЭГ” гэж өөрчилж, 4.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27.Төслийн 4.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “30.1.1, 30.1.3” гэснийг “30.1” гэж өөрчилж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “нөхцөл байдалд ороогүй” гэсний дараа “ нь аюулын зэргийн

болон эрсдэлийн үнэлгээгээр тогтоогдсон” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн эх баригч нь хэн юм? Тамгын газраас.

29.Төслийн 4.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “гэрээ байгуулж болохгүй хүн болох нь хожим илэрсэн,” гэснийг “гэрээг цуцлах үндэслэл” гэж, мөн хэсгийн “цуцалж, хүүхдийг буцаан авна” гэснийг “цуцална” гэж, мөн зүйлийн 6 дахь хэсгийн “цуцалж, хүүхдийг буцаан өгч” гэснийг “цуцалж” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

28.Төслийн 4.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “хүүхдийг гэр бүлээс нь түр тусгаарлах” гэснийг “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30.1-д” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

30.Төслийн 4.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “орон нутгийн байгууллага,” гэсний дараа “хамтарсан баг” гэж нэмж, мөн хэсгийн “кейс

менежмент” гэснийг “тохиолдлын зохицуулалт /кейс менежмент/” гэж, “кейс” гэснийг “тохиолдол /кейс/” гэж тохиолдол бүрд өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт.

Үүнийг гүйцээн боловсруулж, Хэлний зөвлөлөөс тодруулж нэр томьёо гарга. За юу. Шинэ нэр томьёо зохиож байгаа бол Хэлний зөвлөлөөс асуу. Тэр журамтай. Гүйцээн боловсруулах чиглэл өглөө. /алх цохив/

31.Төслийн 6.1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 6 дахь хэсэг нэмэх:

“6.Засгийн газрын гишүүн бүр эрхлэх асуудлын хүрээнд салбарын хүүхэд хамгааллын үйлчилгээ, энэ хуулийн 4.1 дүгээр зүйлийн 3-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгуулах арга хэмжээ авна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

32.Төслийн 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтэд дараах журмаар хяналт тавина:

1.1.аймаг, нийслэлийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд, төрийн

захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага өөрийн хариуцсан салбарын хүрээнд хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр тухайн жилд гүйцэтгэсэн ажлын тайланг дараа оны 2 дугаар сард багтаан хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

1.2.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ зүйлийн 1.1-д заасны дагуу ирүүлсэн тайланд дүн шинжилгээ хийж, жил бүрийн 3 дугаар сард багтаан Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөр хэлэлцэх;

1.3.Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл шаардлагатай тохиолдолд Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох төрийн байгууллагад чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулах.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

59.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

33.Төслийн 7.4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Энэ хуулийг 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

34.Төслийн талаарх саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн дэс дараалал, бүлэг, зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй саналаар санал хураалт явуулья.

1.Төслийн 2.6 дугаар зүйлийн 1.6 дахь заалтын “судалгаа хөтөлж,” гэсний дараа “хүүхэд хамгааллын нэгдсэн” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмэх:

“5.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын дарга Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн байгууллагад 4-өөс доошгүй жил, үүнээс хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнаар хоёроос доошгүй жил ажилласан байна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

47.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй бөгөөд Байнгын хорооны санал унаж, Ажлын хэсгийн санал дэмжигдлээ.

Ц.Идэрбат гишүүн ээ, танай ажлын хэсгийн санал босох нь зөв юм уу, буруу юм уу? Тэгвэл Чимэдийн

Хүрэлбаатар гишүүн горимын санал гаргана.

Ч.Хүрэлбаатар: Уг нь саналаа өгсөн. Энэ хуруу уншсангүй.

Г.Занданшатар: Тэгээд санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргана.

Ч.Хүрэлбаатар: Тийм.

Г.Занданшатар: Гаргаж байна гэж ойлголоо. Ч.Хүрэлбаатар гишүүн энэ санал хураалтыг хүчингүйд тооцох горимын санал гаргалаа.

Дэмжсэн санал нь дэмжигдээгүй байсан учраас. Чимэдийн Хүрэлбаатар гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

Хуулиараа үлдчихээр хууль дахь шаардлага нь бүр илүү өндөр байгаа юм биш биз.

За за. Төрийн албаны хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн байгууллагад 4-өөс доошгүй жил, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнаар хоёроос доошгүй жил ажилласан байна гэсэн шаардлага дэмжигдлээ шүү. Ажлын хэсгийн санал.

Яах вэ, тэгээд л хүүхдийнхээ чиглэлээр ажилласан байна гэж байгаа юм байна.

Найруулгын санал.

1.Төслийн 3.4 дүгээр зүйлийн гарчгийн “мэдээлэл,” гэсний дараа “өргөн нэвтрүүлэг,” гэж нэмэх.

2.Төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.11 дэх заалтын “тодорхой” гэснийг “гэрээнд заасан” гэж, 2.9 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтын “жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан” гэснийг “жилд хоёроос доошгүй удаа” гэж, 3.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Боловсролын сургалтын байгууллагын хүүхдийн эрх, хамгааллын үйлчилгээ үзүүлэх нэгж нь хүүхэд сургалтын” гэснийг “Энэ зүйлийн 1-д заасан байгууллагын” гэж, мөн зүйлийн 2.3 дахь заалтын “хайрцаг байрлуулах” гэснийг “нээлттэй суваг ажиллуулах” гэж, мөн зүйлийн 5.5 дахь заалтын “агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын багш бэлтгэх, давтан сургах сургалтын хөтөлбөрт тусгаж,” гэснийг “агуулга туссан эсэхэд” гэж, 3.6 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “дүүргийн” гэснийг “баг, дүүрэг, хорооны” гэж өөрчилж, 7.3 дугаар зүйлийн гарчгийн “Шилжилтийн үеийн” гэснийг “Хууль дагаж мөрдөх журмын гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “хууль тогтоомж,” гэснийг, мөн зүйлийн тайлбар хэсгийн “тухайн хуулийн этгээдийн ажилтны болон үйлчлүүлж байгаа” гэснийг, 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “хувийн эрх зүйн” гэснийг, 2.12 дугаар зүйлийн 1.4 дэх заалтын “тогтмол хугацаанд” гэснийг, 4.3 дугаар зүйлийн 2.4 дэх заалтын “хөгжлийн, амьдрах ухааны” гэснийг, мөн заалтын “тохиромжтой үйл ажиллагаанд” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал байна.

Нэг.Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын 20.8 дахь хэсгийн “хяналт шалгалт хийхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг баримтлах ба хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүрмийг Засгийн газар батална” гэснийг “хүүхэд аюултай нөхцөл байдалд орсон, орсон байж болзошгүй тохиолдолд хяналт шалгалт явуулах аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламж, ажлын байр, орон байранд урьдчилан мэдэгдэхгүйгээр чөлөөтэй нэвтрэх эрхтэй” гэж өөрчилж, мөн зүйлийн 7 дахь заалтад доор дурдсан агуулгатай 20.9 дэх хэсэг нэмэх:

“20.9.Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн ажиллах дүрмийг Засгийн газар батална.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, П.Анужин,
Б.Баярсайхан, Б.Бейсен, Б.Жаргалмаа.

Цаашид “Ажлын хэсэг” гэнэ. Санал хураалт. /алх цохив/

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 8 дахь заалт нэмэх:

8/20¹ дугаар зүйл:

“20¹ дугаар зүйл.Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч

20¹.1.Сум, дүүргийн Засаг дарга баг, хороо бүрд хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч ажиллууулж болно.

20¹.2.Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч тухайн сум, хорооны байнгын оршин суугч байна.

20¹.3.Сум, дүүргийн Засаг даргын захирамжийг үндэслэн Тамгын газрын дарга хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагчтай гэрээ байгуулах бөгөөд гэрээнд талуудын эрх, үүрэг, хариуцлага, ажил тайлагнах журам, урамшуулал, гэрээ цуцлах үндэслэлийг тусгана.

20¹.4.Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагчтай байгуулсан гэрээг ажлын үр дүнг харгалзан жил бүр сунгана.

20¹.5.Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

20¹.5.1.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, мэдээлэх;

20¹.5.2.хүүхэд эрхээ хэрэгжүүлэхэд нь зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх;

20¹.5.3.хүүхдийн сайн сайхан байдлыг хангахад чиглэсэн санал, санаачилга гаргаж хэрэгжүүлэх;

20¹.5.4.хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

20¹.5.5.хүүхдийн эрхийн зөрчлийн талаар эрх бүхий этгээдэд мэдэгдэж, шийдвэрлүүлэх.

20¹.6.Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хамтарсан баг, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтантай хамтран ажиллана.

20¹.7.Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч нь ажлын улирал тутмын төлөвлөгөөг сум, дүүргийн Засаг даргаар батлуулна.

20¹.8.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагчийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулна.

20¹.9.Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч сум, дүүргийн Засаг даргаас олгосон албаны үнэмлэхтэй байна. Албаны үнэмлэхийн загварыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

20¹.10.Сум, дүүргийн Засаг дарга хүүхдийн эрхийн олон нийтийн

байцаагчид олгох урамшууллын зардлыг орон нутгийн төсвийн төсөлд тусгаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, үр дүнг тайлагнана.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Гочоогийн Ганболд гишүүн.

Г.Ганболд: Сая би энэ орон нутгийн Засаг даргын эрх, үүрэгтэй холбоотой саналыг дэмжсэн юм.

Тэгээд төхөөрөмж ажилласангүй. Саяын санал хураалтыг хүчингүй болгож өгөөч ээ гэж.

Г.Занданшатар: Гочоогийн Ганболд гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулья.

60.5 хувийн саналаар Г.Ганболд гишүүний гаргасан санал дэмжигдлээ.

Үүнийг бас уриа, дуудлагын шинж чанартай. Тэгээд л санал санаачилга гэсэн энэ заалтууд чинь бас болохгүй байгаа шүү.

Санал хураалтыг дахиж явуулья. Хүчингүй болгосон учраас санал хураалт. /алх цохив/

63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 2, 3 дахь заалт нэмэх:

“2/30 дугаар зүйлийн 30.11 дэх хэсэг:

“30.11.Хүүхдийн түр хамгаалан байрлуулах үйлчилгээг төрөлжүүлэн зохион байгуулж болно.”

3/35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэр:

“Төрийн байгууллагын харьяанд байгуулсан түр хамгаалах байрны урсгал зардал, түр хамгаалан байрлуулж энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлэх зардлыг тухайн байгууллага хариуцна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Түрүүчийн Хүүхдийн эрхийн тухай хуулийн 3 дахь санал хураалтыг дахиж явуулья.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн “15 дугаар зүйлийн 15.1.9 дэх заалтын дугаарлалтыг “15.1.10” гэж,” гэснийг хасаж, мөн зүйлийн ““20.5, 20.6, 20.7” дахь хэсгийн дугаарлалтыг “20.9, 20.10, 20.11”” гэснийг “20.5 дахь хэсгийн дугаарыг “20.10” гэж, 20.7 дахь хэсгийн дугаарыг “20.12” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Мөн Хүүхдийн эрхийн тухай хуулийн төсөл.

4.Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмэх:

“5 дугаар зүйл.Хүүхдийн эрхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 2 дахь санал хураалт.

2.Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 1, 2 дахь заалт нэмэх:

**1/18 дугаар зүйлийн
18.1.2 дахь заалт:**

“18.1.2.Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардал, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх;”

**2/19 дүгээр зүйлийн
19.1.5 дахь заалт:**

“19.1.5.тухайн шатны жилийн төсвийн төсөлд нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг тусгаж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах;”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

65.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “сургуулийн,” гэсний дараа “нийгмийн” гэж, мөн хэсгийн “тухайн сум,” гэсний дараа “баг,” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

65.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн “хуулийн” гэсний дараа “5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтын ““гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан баг” цаашид “хамтарсан баг” гэх/” гэснийг “хамтарсан баг” гэж,” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

65.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 4 дүгээр зүйлийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гурав.Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 5.2.5 дахь заалтын “байгуулах” гэснийг “байгуулж, ажиллах журмыг батлах” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дөрөв.Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 19¹.2 дахь хэсгийн “хувь хүн,” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2/13 дугаар зүйлийн 13.13, 13.14 дэх хэсэг:

13.13.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах тохиолдолд хүүхдийн тэтгэмжийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид олгохыг түдгэлзүүлэх шийдвэр гаргана:

13.13.1.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь сураггүй алга болсон;

13.13.2.эцэг, эх нь хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй, эсхүл эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн эрхийг зөрчсөн талаар аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүгнэлт гарсан, хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон.

13.14.Энэ хуулийн 13.1.6-д заасан хүүхдийн мөнгөн тэтгэмжийг зээл, өр төлбөрт суутгахыг хориглоно.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт болгон шилжүүлж, 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3 дугаар зүйл болгох:

“3 дугаар зүйл.Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дэх заалтын, 19 дүгээр зүйлийн 19.1.3, 19.2.3 дахь заалтын “хүнд нөхцөлд” гэснийг “эрсдэлт нөхцөлд” гэж, 13 дугаар зүйлийн 13.13 дахь хэсгийн дугаарыг “13.15” гэж тус тус өөрчилсүгэй.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 4 дүгээр зүйл болгох:

“4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тав.Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зургаа.Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “сурагчдад” гэсний өмнө “оюутан,” гэж, мөн зүйлийн “хүүхдэд” гэсний өмнө “дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагч, эрсдэлт нөхцөлд байгаа” гэж тус тус нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Долоо.Онц байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найм.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1.Төслийн гарчгийн “, ӨӨРЧЛӨЛТ” гэснийг “ОРУУЛАХ” гэж өөрчилж, 2 дугаар зүйлийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.

Ажлын хэсгийн дарга Цагаанхүүгийн Идэрбат гишүүн үг хэлнэ.

Ц.Идэрбат: Хүүхэд хамгааллын хуулийн анхны хэлэлцүүлэг хийгдээд зарчмын зөрүүтэй саналууд дэмжигдсэнтэй холбогдуулаад Байнгын хороо эцсийн хэлэлцүүлэг дээр Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийг нийцүүлж хөндөх хэрэгтэй болж байгаа тул энэ дээр гүйцээн боловсруулах чиглэл өгнө үү гэж хүсэж байгаа юм.

Г.Занданшатар: Төрийн хэмнэлтийн тухай хууль дээр үү?

Үүнийг гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

Энэ чинь Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэдэг нь “өөрчлөлт”-ийг нь хасаад тэгээд “нэмэлт оруулах” тухай хууль болгоод тэгээд 2 дахь заалтдаа өөрчлөлт оруулж байсан хэсгийг хасаж байгаа тийм л хэсэг юм байна шүү дээ.

Төрийн худалдан авалтын тухай хууль энд байхгүй шүү дээ.

Тэрийг хууль батлагдсантай холбогдуулаад хуулийн төслийг Байнгын хороо санаачилж болох дэгээр эцсийн хэлэлцүүлэг дээр санаачилж явна. Та нар. Байнгын хороо санаачилна. П.Анужин гишүүн.

Тэгээд энэ санал хураалтыг явуулья. Тийм ээ. Санал хураалт явуулья. /алх цохив/

64.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ес.Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

56.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлж байна.

Энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүдэд мэндчилгээ дэвшүүлье.

01 сарын 02-нд Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учрал төржээ.

01 сарын 06-нд Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд төржээ.

Манай Н.Учрал гишүүн Намсрайн Ням-Осор, Жамбалын Цэцэгмаа нарын айлын ууган хүүхэд болж 01 сарын 02-нд эхээс мэндэлсэн.

Манай Нямаагийн Энхболд гишүүн Мандайгийн Нямаа, Гүрийн Тогтох нарын ууган хүүхэд болж 01 сарын 06-нд эхээс мэндэлсэн.

Тэгээд Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учрал, Нямаагийн Энхболд нарт төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон Танд болон танай гэр бүлд Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе. /алга ташив/

Мөн Увс аймгийн Өндөрхангай сумын харьяат Гонгорын, Ховд

аймгийн Булган сумын харьяат Басан нарын отгон хүү болж Улсын Их Хурлын гишүүн Дамдинням 01 сарын 09-ны өдөр эхээс мэндэлсэн байна.

Ингээд Гонгорын Дамдинням гишүүндээ төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн түшээ, ард

түмний элч болсон Танд болон танай гэр бүлд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе. /алга ташив/

Ингээд үдээс өмнөх чуулганы хуралдаан үүгээр өндөрлөж байна.

З А В С А Р Л А Г А

Г.Занданшатар:

Д.Тогтохсүрэн дарга аа, даргын дэргэдэх зөвлөлөө одоо хуралдуулчих уу? Даргын дэргэдэх зөвлөлөө одоо хуралдчих юм уу? Тэгье.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал өндөрлөсөн байна.

Ингээд маргааш хуулийн төслийг үргэлжлүүлж хэлэлцэнэ.

Одоо даргын дэргэдэх зөвлөл хуралдах тул Улсын Их Хурлын чуулганы өнөөдрийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 2 цаг 15 минут үргэлжилж, 14 цаг 32 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД